

**Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ  
УЛААНБААТАР ХОТЫН  
НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН  
2019 ОНЫ ҮР ДҮНГИЙН  
ГЭРЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2019 он

## ТАЙЛАНГИЙН ДОТООД ТОВЪЁОГ

№	Бүлгийн нэр	Хуудасны дугаар
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн	1 – 10
2	Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн	10 – 17
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүн	17 – 36
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	36 – 37
5	Бусад мэдээлэл	37 – 51

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН  
НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН  
БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон нийтэд мэдээ мэдээллийг түгээх, тэдэнд зориулсан соёл танин мэдэхүй, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлуудыг дараах байдлаар зохион байгуулан ажиллав.

*3.2.1 Нийслэлийн суурьшлын бүсийн хөрсний доройтол, бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх, суурь судалгааг оновчтой хийж, олон нийтэд хөрсний бохирдлын талаар ойлголт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна.*

Олон нийтэд хөрсний бохирдлын талаар ойлголт, мэдээлэл өгөх ажлын хүрээнд: “Их хотын иргэдийн экологийн боловсролд”, “Аз жаргалтай, утаагүй Улаанбаатар” сэдэвтэй

“Агаар ба хөрсний бохирдол” сэдэвчилсэн үзэсгэлэн,  
“Ус хамгийн чухал хэрэглээ” мэдээллийн үзэсгэлэн  
“Монгол орон дахь уур амьсгалын өөрчлөлт”  
“Ногоон хөгжилд иргэдийн оролцоо” сэдэвчилсэн үзэсгэлэн  
“Экологи” сэдэвчилсэн үзэсгэлэн  
“Ус чандмань эрдэнэ” мэдээллийн үзэсгэлэн  
“Аялахад тохиромжтой монголын үзэсгэлэнт газрууд”  
“Агаарын бохирдол бидний эрүүл мэндэд”  
“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”  
“Ногоон хувьсгал” сэдэвчилсэн үзэсгэлэн  
“Экологи, эрүүл мэнд” сэдэвт байнгын үзэсгэлэнгүүдийг тус тус гарган сурталчилсан ба нийт 920 гаруй уншигч, үйлчлүүлэгч үзсэн байна.

Мөн “Утааны хор уршгийн тухай, маскны хэрэглээ”, “Ногоон Улаанбаатар”, “Хөрсний бохирдол”, “Ногоон орчин-Бидний ирээдүй”, “Ногоон орчин байгал эх дэлхийгээ хайрлая”, “Дэлхийн тамхигүй өдөр”, “Хүнсний аюулгүй байдал-эрүүл мэнд” зэрэг сэдвээр нийт 51 ширхэг хэвлэмэл хуудсаар тус тус мэдээлэл гаргаж сурталчлав.

*4.1.17. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Эрдмийн аялал” аян зохион байгуулж, Шинжлэх ухааны Академийн харьяа хүрээлэн, номын сан, музей, түүхийн дурсгалт газар, орон нутгийн байгууллага, үндэсний үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах аяллыг тогтмол зохион байгуулна.*

“Эрдмийн аялал” аяны хүрээнд:

- 27, 40, 41, 46, 65, 67, 72, 101, 104, 112, 120, 214, 243, 252, 261-р цэцэрлэгийн Бэлтгэл А, Б, В, Г бүлгийн 490 орчим хүүхэд багачуудад
- Ерөнхий боловсролын 1, 5, 11, 18, 23, 31,33, 52, 62, 85-р дунд сургууль,
- Харааны бэрхшээлтэй 116-р сургуулийн 1-5-р ангиуд, Номт наран сургуулийн 1-р анги, Шилдэг дунд сургууль, Ирээдүй цогцолбор 2-р бага сургуулийн 4д, 6д, Атланта сургууль, ОУ-ын Улаанбаатар дунд сургуулийн 7 дугаар анги, Эрхэт эрдэм ерөнхий боловсролын сургуулийн 2-р анги
- Булган аймгийн Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12-р анги, Төв аймгийн Борнуур сумын ЕБС, Хэнтий аймгийн Р. Чойномын нэрэмжит номын сангийн идэвхтэй уншигчид "Өсвөрийн сэтгүүлч" клубын хүүхдүүд
- Шинэ иргэншил дээд сургуулийн МСҮТ, Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн 20, Ач АУИС-ийн оюутан нийт 1402 оюутан, сурагч, иргэдийг төв болон салбар үйл ажиллагааг танилцуулж, уншигчаар бүртгэн, уншсан номынхоо талаар саналаа солилцож тэмдэглэл хөтлөх арга ажиллагааны талаар тойм яриа зохион явууллаа.



### 4.3. Соёл, урлаг

4.3.1. Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд болон олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох “Иргэдийн оролцоотой Хотын соёл” олон нийтийн аяныг өрнүүлнэ.

Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор НЭГ ХОРОМ, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө сэдвүүдээр Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Прокурорын газрын Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтын прокурор Т.Жавхлантөгстэй уулзалт хийлээ. Уулзалтанд 31-р сургуулийн 46 ангийн 21 сурагчид оролцлоо.



Хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, бусдаас суралцах арга барилыг эзэмшүүлэх зорилгоор Зохиолч Луужир Жиймийгийн “Намайг өөрчилсөн 85 эмэгтэй” номын хэлэлцүүлэг, уулзалтыг зохион явууллаа. Уулзалтад 24 уншигч, бүсгүйчүүд хамрагдлаа.



Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г. Очбаяраар бяцхан уншигч, нийслэлчүүддээ Улаанбаатар хотын түүх, соёлын талаар “Бид ямар хотод аж төрөн амьдардаг вэ?” сэдвийн хүрээнд лекц уншуулж, харилцан яриа хийлээ. Уулзалтад 31 дүгээр сургуулийн 30 гаруй сурагч хамрагдлаа.



Нийслэлийн 380 жилийн ойг угтаж “Хотын соёл-Номноос эхлэнэ” уулзалтыг Хүүхдийн зохиолч О.Сундуйтай БЗД-н Гачуурт тосгоны 85 сургуулийн 56 ангийн Н.Сувдаа багштай ангийн сурагчдын дунд номын санч Д.Дэлгэрсайхан, ном зүйч О.Долгорсүрэн нартай хамтран зохион байгуулж ажилласан. Уг арга хэмжээнд нийт 135 сурагчид хамрагдсан.

*4.3.2. Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн үйлчилгээг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн цахим хэлбэрт шилжүүлж, алслагдсан дүүргийн соёлын ордны номын сангийн хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлнэ. Тус заалтын хүрээнд:*

1. Коха програмд ном каталогжуулж оруулах ажлын явц тайлант хугацааны байдлаар:

- Багануур дүүргийн соёлын ордны номын сан 9655 ш – 74,8%
- Багахангай дүүргийн соёлын ордны номын сан 1619 ш – 79%
- Жаргалант дүүргийн соёлын ордны номын сан 418 ш – 15.9%
- Налайх дүүргийн соёлын ордны номын сан 2599 ш – 23,6% номуудыг тус тус оруулаад байна.

2. Төв болон салбар номын сангийн үйлчилгээнд RFID технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай үлдэгдэл тоног төхөөрөмжийн судалгаа гарган 2019 оны 04 дүгээр сард Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт тендерийн материалыг хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдөр тендер зарлагдан “Ай Ти Зон” ХХК шалгарсан.

Нийслэлийн Засаг даргын тамгын газар “Ай Ти Зон” ХХК-тай 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр “Төв болон салбар номын санд RFID системийн компьютер, бусад тоног төхөөрөмж нийлүүлэх” гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр эхний ээлжийн тоног төхөөрөмжүүдийг хүлээн авсан. Тус компани БНХАУ руу барааны захиалгыг хийсэн ба VC-420T RFID EAS GATES хаалганы үйлдвэрлэх процесс удааширсны улмаас гэрээнд заасан хугацаандаа ирж амжихгүй болсон тул тухайн гэрээг 12 дугаар сарын 09-ний өдөр хүртэл сунгасан.

“Ай Ти Зон” ХХК-иас 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдөр дараах нэр төрлийн тоног төхөөрөмжүүдийг хүлээн авсан.

№	Загвар	Нэр	Тоо ширхэг
1	VC-420T	RFID хаалга	6
2	LA-86B	RFID чип	174000
3	R-0407	RFID чип хэвлэх принтер	1
4		RFID чип хэвлэх принтерийн хор	40
5	VD-67	RFID чип уншигч	15
6	VH-71T	RFID гар тоологч	4
7	VD-68	RFID уншигчийн карт уншигч	11
8	Zebra p330	RFID уншигчийн карт хэвлэх принтер	4
9	VT-80	RFID уншигчийн картын бэлдэц	18400
10		RFID уншигчийн карт хэвлэх принтерийн хор	40
11	CCR1009-7G-1C-1s	Роутер	4
12	TP-link	Свич	4
13	Dell inspiron 15 3555	Нөүтбүүк	1
14	Dell optiplex 3050	Компьютер	15
15	Dell PowerEdge R740	Сервер компьютер	1

3. Төв номын сангийн засварын зураг төслийг “Уранстийл Воркс” ХХК-иар хийлгэн 2019 оны 08 дугаар сард Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр тендер зарлагдан “Цагаан Удам” ХХК шалгарсан. Одоогийн байдлаар дотор засварын ажил хийгдэж байгаа ба 60%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

#### 4.5. ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ:

4.5.7. Нийслэлд “Гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэхийг хэвшүүлж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгож, тогтвортой харилцааг төлөвшүүлнэ.

Чингэлтэй дүүргийн алслагдсан Ерөнхий боловсролын 58 дугаар бүрэн дунд сургуулийн номын өргөөтэй хамтран гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Тус өдөрт зориулан нийтийн уншлагын танхимаас Монголын сурагчдын холбооны сэтгэл зүйч Б. Тэгшжаргалыг урин "Гэр бүлийн үнэ цэнэ" сэдэвт уулзалт ярилцлага зохион байгуулж 70 сурагч хамрагдсан байна.

Мөн Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сангийн хүүхдийн уншлагын танхимаас "Гэр бүл өнөөдөр" сэдэвт эсээ бичлэгийн уралдаан явуулж эхний 5 байрыг шалгаруулан шагнаж урамшууллаа. Нийтийн уншлагын танхимын номын санчид 2019-2020 оны хичээлийн жилд тус сургуулийн номын өргөөтэй хамтран номын клуб байгуулан хамтарч ажиллаж, хүүхдийн уншлагын танхим тус сургуулийн 2-3 ангийн хүүхдүүдийг уншигчаар бүртгэн зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүллээ.



Сүхбаатар дүүргийн 45-р сургуулийн 4а, 4б, 4в, 4г бүлгийн 160 сурагчдад "Цахим хэрэгслийг хэтрүүлэн хэрэглэсний хор нөлөө буюу зохистой хэрэглэсний ач холбогдол" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Байгууллагын page хуудсаар дамжуулан эцэг эх, хүүхэд багачуудад зориулсан "Хүүхдэдээ ном уншиж өгөөрэй", "Гэр бүлийн харилцааг эрхэмлээрэй" сэдэвт зурагт мэдээлэл зөвлөмжийг тогтмол оруулж 60 хүн хандсан байна.

Дээлтэй монгол наадамд зориулан нүүдэлчдийн соёлын чухал хэсэг болсон "Монгол үндэстэн ястны дээл, гоёл чимэглэлийн тухай 12 ширхэг хэвлэмэл хуудсаар үзэсгэлэн гаргаж сурталчлав. Монголын ирээдүй болсон хүүхэд, залууст түүх, соёл өв уламжлалаараа бахархах ухамсрыг төлөвшүүлэх, таниулахад оршино.

АНУ-ын ЭСЯ-тай хамтран Бүтээлч иргэнийг төлөвшүүлэх, дэмжих зорилгоор МэйкерСпейс танхимыг 60 сая төгрөгөөр засварлан тохижуулж, 70 гаруй сая төгрөгөөр тоног төхөөрөмж, суралцагчдын ашиглах хэрэглэгдэхүүн авч үйл ажиллагааг эхлүүлээд байна. Ингэснээр тус танхимд Лего тоглоомын хөтөлбөр, 3D принтер ажиллуулах, Ардиано хийх сургалт, Хувцас загвар, оёдол дизайны сургалтууд явагдаж байна. 2019 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нээгдсэн ба одоогийн байдлаар 189 уншигч, үйлчлүүлэгч сургалт, хөтөлбөрт хамрагдаад байна.





Хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилго бүхий Лего тоглоомын хөтөлбөрийн зарыг олон нийтэд Фэйсбүүк хуудсаараа дамжуулан хүргэж байна. Уг хөтөлбөрт хамрагдахын тулд урьдчилан цагаа бүртгүүлэн тоглох журмаар явагдаж байгаа бөгөөд 7 хоногийн 6 өдөр 09:00-18.00 цаг хүртэл эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамтдаа ирж тоглох боломжтой хөтөлбөр юм. Нийтдээ 21 хүүхэд, 6 насанд хүрэгч шинээр карт нээлгэн тус хөтөлбөрт хамрагдаж байна.

Хүүхдүүдэд зориулсан картын тоглоомын хөтөлбөр нь Мягмар гараг бүрийн 14.00 цагаас явагддаг ба нийтдээ 3 удаа удаагийн хичээлд 22 хүүхэд хамрагдсан байна. Энэхүү тоглоомын цагаар англи хэлний үгийн сангаа баяжуулах, дүрмийн мэдлэгээ дээшлүүлэх мөн байгалийн ухаан болон инженерчлэлийн сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой 14 төрлийн тоглоомыг багаар болон ганцаарчлан тоглох боломжтой юм.



2019 оны 06 дугаар сарын 19-өөс 10 дугаар сарын 02-ныг дуустал 3D загварчлал, Ардиано төслийн сургалтын 5 удаа зохион байгууллаа. Уг сургалтад нийт 211 сурагч хамрагдах хүсэлтээ ирүүлсэн бөгөөд сонгон шалгаруулалт болон танхимын багтаамжаас шалтгаалан 68 сурагчийг сургаж, төгсгөлөө. Сургалтаар электроникийн онол, дадлага, 3Д принтер загварчлал, багийн ажиллагааны хичээлүүдийг мэргэжлийн багш нараар заалгаж байлаа. Тус сургалтын төгсөгчид Super Cleaner/Супер цэвэрлэгч/, Jarvis /Бяцхан өргөгч/, Switcher /Гэрэл мэдэрч ажилладаг машин/, Өглөөний гайхамшиг/Сэрүүлэг/,



Дохиоллын систем, Ухаалаг гудамжны гэрэлтүүлэг, Ухаалаг авто зогсоол, Халуун мэдэрч асдаг гэрэл зэрэг бүтээлүүдийг хийж, олон нийтэд дэлгэн үзүүллээ.



Лего тоглоомоор робот угсрах, шинээр програмчилах сургалт 11 удаа зохион байгуулж нийтдээ 84 уншигч хамрагдаж номын сангийн уншигчаар бүртгүүлсэн. Лего тоглоом угсрах сургалтыг урьдчилан цаг захиалан бүртгүүлдэг бөгөөд өөрийн хүчин чадлын боломжоор нэг удаад 3 сурагч тоглох боломжтой байсан ба АНУ-ын ЭСЯ-ны ОНХА-нд хүсэлт гаргаж шинээр 1100 ам.долларын легомайндстор тоглоом авсан. Мөн тус сургалтын үр дүнд сурагч бэлтгэгдэж сайн дурын сурагчдын “Монголиан майднсторм клуб” нээж 2 удаагийн тэмцээнд амжилттай оролцсон амжилт үзүүлсэн байна.



Арабын Нэгдсэн Эмират Улсын Элчин сайдын яамны буцалтгүй тусламжийн 55 сая төгрөгөөр Хүүхдийн уншлагын танхимдаа бүрэн засвар, тохижилтын ажлыг хийлээ. Хүүхдийн уншлагын танхимд сурагчдын өвлийн амралтад зориулан чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэхэд нь туслах, номын санд уншигч татах зорилгоор “My first English”



Англи хэлний анхан шатны сургалтыг 2, 3, 4, 5-р ангийн сурагчдад 7 хоногт 1 удаа зохион байгуулж нийт 22 удаа бага ангийн 316 сурагчийг хамруулжээ.

Хүүхдийн эрхийн хамгаалах өдөрт зориулан 1950-1980 оны хоорондох хүүхдийн ном зохиолуудаар /34 ширхэг / үзэсгэлэн гаргалаа.

“Миний дуртай ном” номын танилцуулгыг 3 удаа хийж 23 сурагчийг хамрууллаа. Уг танилцуулгаар “Таши” цуврал, Барак Обамагийн “Охиддоо бичсэн захидал” номуудын танилцууллаа.

“Зуны Амралт Ба Ном” хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн Йогийн хичээлийг 3 удаа зохион байгуулж 21 хүүхдийг хамрууллаа. Сургалтыг "Sunderia Yoga" төвийн сургагч багш Н. Сүндэрьяа багш удирдан явууллаа.



“Let's speak” номын хэлэлцүүлгийг 3, 4, 5 дугаар ангийн сурагчдад 3 удаа зохион явуулж 18 хүүхдийг хамрууллаа.



Сургагч багш С. Оюунгэрэлтэй хамтран "Номын сантай танилцъя" хөтөлбөрийн хүрээнд "Оюун ухааны клуб"-ын сурагч хүүхдүүдэд номын сангаа танилцуулан “Ном уншихын ач тус”, “Номтой нөхөрлөхийн гавъяа” сэдвүүдээр ярилцлага хийв.

Монсудар хэвлэлийн газартай хамтран эцэг эхчүүдэд зориулсан “Зурагт ном яагаад чухал вэ?” цуврал уулзалт ярилцлагыг зохион байгууллаа. Уг уулзалтаар Бумбардай номыг

ярилцсан юм. Уулзалтыг нийгмийн сүлжээгээр лайв буюу шууд дамжуулан үзүүлсэн бөгөөд одоогийн байдлаар 1000 гаруй удаа үзэгдээд байна.

# ЗУРАГТ НОМ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

ЦУВРАЛ УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА

## 1 БУМБАРДАЙ



2019 оны 04 дүгээр сарын 26-нд “Газар дэлхий-Бидний гэр” Олон улсын хүүхэд залуучуудын хөгжмийн XVII их наадмын өдөрт зориулж Гитарчин Д.Энхболдтой уулзалт ярилцлага хийлээ. Уулзалт ярилцлагад нийт 55 оюутан, залуус хамрагдлаа.



“Би хариуцлагатай аав ээж” аяны хүрээнд 31-р сургуулийн 4-ангийн сурагчдад “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл гэж юу вэ? Урьдчилан сэргийлэх арга зам” сэдвээр лекц хийж, хүчирхийллийн эсрэг боршур тараалаа.

Нийслэлийн Хүүхэд Гэр Бүл Хөгжлийн Газар, Нийслэлийн 152 хороонд зохион байгуулсан “Би хариуцлагатай-ААВ, ЭЭЖ” аяны хүрээнд 31 дүгээр сургуулийн 6 дугаар ангийн сурагчдын дунд “Эцэг эх хүүхдийн үүрэг хариуцлага” семинар зохион явуулав. Семинарт 53 сурагч хамрагдлаа.

“Соёмбо пресс” хэвлэлийн компанитай хамтран Кембрижийн сургалттай “Шинэ эхлэл” 8-р сангийн 30 сурагчдад “Дэлхийн шилмэл зохиолын дээжис 191 боть” ном

бэлэглэв. Энэ үеэр зохиолч, сэтгүүлч А. Амарсайхан “Номын тэмдэглэл хэрхэн тухай”, номын санч Ж. Рая “Би яагаад номын санч мэргэжлийг сонгох болов” сэдвээр яриа хийлээ.



“Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, урьдчилан сэргийлэх талаар Нийслэлийн Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн Цагдаагийн хошууч Э.Баярбаясгалантай уулзалт ярилцлага зохион байгуулж өргөн хүрээтэй болж 60 гаруй уншигч сурагчид оролцлоо.



## Хоёр. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүр улс орон даяар уламжлагдан зохион байгуулагддаг “Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-үүдээр дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:**

### **Уралдаан, тэмцээн**

Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сан “Эх хэлээ дээдэлье” уран илтгэлийн уралдааныг уламжлал болгон зарлаж байгаа бөгөөд анхны жилдээ зохион байгуулж шилдэг уран илтгэгчийг шалгарууллаа.



ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ ЗОРИЛГО Оюутан, сурагчдыг өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, эх болсон Монгол хэлээрээ уран яруу, зөв ярих дадал олгох, эх хэлээ дээдлэх ухамсар олгох, эерэг өөрчлөлтийг бий болгож соён гэгээрүүлэхэд оршино. Шалгарч үлдсэн хүүхдүүд



Уран илтгэлийн уралдаанд Их сургуулийн бакалаврын төвшний оюутнууд, ЕБС-ийн 10-12 ангийн сурагчид оролцлоо. “Эх хэлээ дээдэлье”, “Эх хэлээ хайрлая”, “Эх хэлээ эвдэхгүй юмсан” гэсэн сэдвийн хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 10–ны өдрийн 15 цагт Горькийн нэрэмжит салбар номын санд зохион байгуулагдлаа. Гадаад үг хэллэг оруулахгүй, Монгол хэлээрээ цэгцтэй, ойлгомжтой ярьж бичих гэсэн ерөнхий шаардлага хангасан 36 оюутан, сурагчдаас шилдэг 8 сурагч, оюутныг сонгон илтгэлийг яриулан шилдэг 3 илтгэгчийг шалгаруулж өргөмжлөл, ном, тусгай байрын шагналаар шагнаж урамшууллаа.

Шилдэг илтгэгчид



Хамтран ажилласан Идэр Их сургууль, ИЗИС, ЕБ 111,16-р сургуулийн сурагч, оюутан, багш нар 70 хүн оролцлоо.

Хамтран ажилласан ИИС-ийн багш ажилчид



### “Алтан үсгийн цоморлиг” уралдаан

“АЛТАН ҮСГИЙН ЦОМОРЛИГ-2019” оны уралдаанд 15 бүтээл ирснээс тэргүүн байранд ШУТИС График дизайн 1-р курсын оюутан Б. Өсөх-Эрдэнэ, дэд байранд Санхүү эдийн засгийн их сургууль 3-р курсын оюутан М.Данзанпэрэнлэй, гутгаар байранд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Ерөнхий Боловсролын сургуулийн 11А ангийн сурагч Б.Гийхнаран шалгарлаа.



### Уулзалт, лекц

“Монгол өв соёл, үнэ цэн” лекцийг Урлаг судлалын магистр Х.Эрдэнэбаяр оюутан сурагчдад өсөхөөс төрсөн үндэсний хэл мартаж болшгүй соёлын сайхныг мэдрүүлсэн, монгол хэл соёлоороо бахархах, ном эрдмийг эрхэмлэх, монгол бичгийн уран бичлэгийн тухай ярьж, үндэсний эх хэл бичгээрээ бахархаж явахын үнэ цэнийг уншигчдад ойлгуулан таниулсан сонирхолтой лекцийг хийлээ.





"Бичиг үсгийн соёл" сэдэвт уулзалтыг Монгол улсын зөвлөх багш, Ертөнц бүрэн дунд сургуулийн Монгол хэл уран зохиолын багш А.Цэнгэлтэй хийлээ. Уулзалтанд 50-р сургуулийн 9в ангийн 46 сурагч оролцлоо.

Үндэсний бичиг үсгийн баяраар Идэр их сургуулийн монгол хэл, уран зохиолын багш, хэл судлалын магистр Д. Уянга, эх хэлээ эрхэмлэн дээдэлж, бичиг

соёлын

дурсгалаа сурталчилах зорилгоор ХУД-ийн ЕБС-ийн 9-12 ангийн нийт сурагчдад "Яагаад бидэнд Монгол бичиг хэрэгтэй вэ?" сэдвээр сургалт хийлээ. Уулзалт сургалтад 139 сурагч хамрагдлаа.



### Үзэсгэлэн

Мөн МУ-ын УГЗ, Төрийн шагналт асан МУ-ын төрийн сүлд бүтээгч Ц.Ойдовын уйгаржин монгол бичгээр бичсэн уран бичлэгийн 14 ширхэг бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчлав.



Зураач О.Андимана "Монгол бичиг мину" уйгаржин монгол бичиг, таталган бичиг, бийрэн бичлэгийн талаар каллиграфийн хичээлийг оюутан сурагчдаар муутуун цаасан дээр бичүүлж, цэвэрхэн зөв бичсэн 5 уншигчийг шалгаруулж дурсгалын зүйл гардуулав.



ЕБС-ийн СБД-ийн 16-р сургуулийн нарийн бичгийн дарга А.Бямбасүрэнгээр ахлуулсан 11-р ангийн 50 сурагч, нийт 65 хүн хамрагдлаа.



"Эх хэлний тань мэдлэгт", мөн "Монгол бичгийн түүхээс" үзэсгэлэнг 10 ш ном, 10 ш хэв 14 ш бүтээлээр гаргаж сурталчилсан.



Уйгаржин монгол бичгээр 20 ширхэг номоор, Монголчуудын бичиг үсгийн түүхийг 10 ширхэг хэвлэмэл хуудсаар сурталчилла. Үүнд: Монгол бичиг, Соёмбо үсэг, Дөрвөлжин үсгийн гарал үүслийг тухай мэдээлэл гаргав.





Үндэсний бичиг үсгийн баяр арга хэмжээнд нийт 28 ш бүтээл, 30ш ном, 20ш хэвлэмэл хуудсаар үзэсгэлэн гаргаж, 2 удаагийн уралдаан тэмцээнд 41 оюутан сурагчид оролцож, ЕБ-ын 16, 50, 111-р сургуулийн 9-12 ангийн 96 сурагч, ИЗИС- Идэр ИС-ийн 66 оюутан оролцлоо. Нийт 181 хүн хамрагдлаа.

### **Эрдмийн аялал**



ХУД-ийн 67-р цэцэрлэгийн х. Ундармаа багштай бэлтгэл А бүлгийн 52 хүүхэд, х. Юмчигмаа багштай бэлтгэл Б бүлгийн 40 хүүхэд, х. Даваасүрэн багштай бэлтгэл В бүлгийн 53 хүүхэд, нийт 145 хүүхэд, “Шилдэг” дунд сургууль, 48, 33-р сургуулийн нийт 110 хүүхэд тус тус оролцож номын сантай танилцан, үлгэрийн цаг гарган харилцан ярилцаж, үлгэрийн кино үзүүлэв.

### **2. Нийслэлийн Засаг даргын 2012 он “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/606 дугаар захирамж**

Тайлангийн хугацаанд иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1488 жиргээ илгээгдэж, 443 дагагчтай, байгууллагын фейсбүүк хуудас 38489, үүнээс гадна АСМТ 17971 дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг түгээж байна.

### **3. Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Мэдээллийн аюулгүй байдлын журам” А/477 дугаар захирамж**

Мэдээллийн системийг холбогдох стандартын дагуу зохион байгуулж ажилладаг бөгөөд номын сангийн үйл ажиллагаа, цаг үеийн шинжтэй мэдээлэл, шилэн дансны мэдээллийг нийтэд [ub.pl.gov.mn](http://ub.pl.gov.mn), UB Public Library.Facebook цахим хуудсанд тухай бүрт байршуулж байна.

Байгууллага дотооддоо захирлын тушаал, үүрэг даалгавар, ажилтан, албан хаагчдын хувийн хэрэг, өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллүүдийг ажилчдын дотоод Facebook page болон дотоод сүлжээгээр мэдээллэдэг.

Номын сангийн нийт байр талбайн 10 хүртэлх хувь буюу үндсэн фонд болон Серверийн өрөө хаалттай бүсэд тооцогддог. Үндсэн номын фонд, серверийн өрөөнд зөвхөн эрх бүхий албан тушаалтан нэвтрэх эрхтэй бөгөөд аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажилладаг.

Ашиглагдаж байгаа бүх компьютер техник хэрэгслийг мэдээллийн ажилтнууд бүртгэлжүүлж, засвар үйлчилгээ, шинэ програм хангамж нэмэгдэх бүрт програмист болон хариуцагч ажилтан нар гарын үсэг зурж баталгаажуулдаг.

Мэдээллийн системийг хууль бус халдлагаас хамгаалах галт хана ашиглаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх оролдлогыг таслан зогсоох, илрүүлэх зориулалтаар хамгаалалт, хяналтын техникийн систем, зориулалтын програм хангамжид байнга хяналт тавьж ажиллаж байна.

#### 4. Нийслэлийн Засаг даргын 2014 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх тухай батлах тухай” А/718 дугаар захирамж

<http://koha.pl.ub.gov.mn> -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2018 оны 12 дугаар сарын 25-аас 2019 оны 12 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацаанд 87178 хэрэглэгч зочилж /visits/, 279314 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 85,3% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 14,7% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.



Тайлангийн хугацаанд сайтад зочилсон хэрэглэгчдийг эхний 10 улс орноор харуулав.

Country	Users	% Users
1. Mongolia	43,687	88.7%
2. United States	2,676	5.44%
3. (not set)	878	1.78%
4. South Korea	404	0.82%
5. Japan	277	0.56%
6. Russia	250	0.51%
7. China	143	0.29%
8. Germany	97	0.20%
9. United Kingdom	85	0.17%
10. Australia	57	0.12%

#### 5. Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам батлах тухай” А/633 дугаар захирамж

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журмын дагуу ажлаас чөлөөлөгдсөн 4, шинээр болон эгүүлэн томилогдсон 10, шилжин ажилласан 4 ажилтнуудын ажил хүлээлцэх комиссын гишүүдийг томилж, уг журмын хавсралт ажил хүлээлцэх маягтын дагуу цахим болон цаасан баримт, эд хөрөнгийг хүлээлцүүлэн тус бүр 3 хувь үйлдсэн.

## **6. Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам батлах тухай” А/252 дугаар захирамж**

Тайлант хугацаанд Edoc системд нийт ирсэн 185 албан бичиг бүртгэгдсэнээс цахимаар 182, цаасан суурьтай 3 албан бичиг ирснийг бүртгэсэн. 179 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хаасан, 3 албан бичгийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж, 3 албан бичиг судалж буй төлөвтэй байна.

Мөн Edoc системээр нийт явуулсан 127 албан бичгийг бүртгэж илгээсэн ба үүнээс албан хэрэг хөтлөлтийн систем ашигладаг 87, систем ашигладаггүй 40 байгууллага руу албан бичиг бүртгэн хугацаанд нь шилжүүлж шийдвэрлүүлсэн. Системийн боловсруулалт цэсийг ашиглан 8 албан бичиг илгээсэн.

Систем ашиглалтын зөрчилтэй 5, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 3, шийдвэрлэлтийн зөрчилтэй 8 албан тоот илэрснийг холбогдох ажилтнуудад мэдэгдэж дахин зөрчил гаргалгүй ажиллах тал дээр зааварчилгаа, зөвлөгөө өгсөн.

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг сард 2 удаа гаргаж, удирдлагад 24 удаа танилцуулж ажилласан.

Улсын үзлэгт бэлдэх комисс 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Захирлын 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлагдаж, үзлэгт бэлтгэсэн. Үзлэгт бэлдэх 21 ажил бүхий тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан бөгөөд Нийслэлийн салбар комисст ажлаа шалгуулж Төрийн ажлын зохион байгуулалт 84.3%, Албан хэрэг хөтлөлт 84.4%, Байгууллагын архив 91.4%, Мэдээллийн технологи 93.1%, Дундаж үнэлгээгээрээ **88,3% “В”** үнэлэгдсэн.

2018 оны баримтаар нөхөн бүрдүүлэлт хийх ажлыг Нөхөн бүрдүүлэлтийн хуваарийн дагуу хийлээ. ХХНЖ-ын дагуу 2018 оны Байнга хадгалах-23, 70 жил хадгалах-4, Түр хадгалах – 28, Цахим баримт- 2, нийт 57 баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийж, данс бүртгэлийг үйлдэн ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэн баталсан.

Байгууллагын “Албан хэрэг хөтлөлтийн журам”, “Архивын ажиллах журам”-ыг ажиллагсад тараан, журам танилцуулах сургалтыг нэгж тус бүрт 1, нийт 5 удаа Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан, төв салбар номын сангууд гэх мэтээр тухайн ажлын байранд нь хүрч хийсэн нь ихээхэн үр дүнтэй, ажиллагсдын талархлыг хүлээсэн сургалт болсон.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

### **3.1. Уншлага үйлчилгээ**

Номын сангийн хэмжээнд тайлант хугацаанд бүтээгдэхүүн нийлүүлэлтийг “хүснэгт 1”-ээр үзүүлбэл дараах байдалтай байна.

### Хүснэгт 1

д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Бүртгэлтэй уншигч	19300	14728	76,3%
2	Ирэгсэд	119700	101400	84,7%
3	Ном олголт	299250	241957	80,8%
4	<b>НИЙТ ДҮН</b>	<b>438250</b>	<b>358085</b>	<b>81,7%</b>

Уншлага үйлчилгээний төлөвлөгөөт үзүүлэлтүүд 76-84%-ийн биелэлттэй байгаа бөгөөд тайлант хугацааны төлөвлөгөөт үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:


### Хүснэгт 2

Он		2018			2019		
№	Үйлчилгээ нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Бүртгэлтэй уншигч	19300	<b>14349</b>	74,3%	19300	14728	76,3%
2	Ирэгсэд	119700	<b>106076</b>	88,6%	119700	101400	84,7%
3	Ном олголт	299250	<b>235299</b>	78,6%	299250	241957	80,8%

2019 оны уншигчийн төлөвлөгөө 76,3%-ийн биелэлттэй байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийн биелэлттэй харьцуулахад **2%-иар** өссөн байна.

### 3.2. Гэрээр ном олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд уншигч хэрэглэгчдэд **241957** ном хэвлэл олгож үйлчилснээс 12,3% буюу **29799** ширхэг номыг гэрээр олгож үйлчилсэн байна.



Тайлант хугацаанд ном олгох үйлчилгээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Он		2018			2019		
№	Үйлчилгээ нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Ном олголт	40830	<b>40920</b>	100%	40830	<b>29799</b>	72,9%

Тайлант хугацаанд гэрээр ном олгох үйлчилгээ 72,9%-ийн биелэлттэй байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийн биелэлттэй харьцуулахад **27,1%**-иар буурсан үзүүлэлттэй байна.

### Тайлбар

1. Тайлант хугацаанд төв болон салбар номын сангийн хэмжээнд ажил хүлээлцэх ээлжит бус 4 удаагийн тооллого /Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан, төв номын сангийн уншлагын Б танхим/ хийгдсэн. Нийт ажлын 95 өдөр зарцуулсан.

2. Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангуудад Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2018 оны 09 дүгээр сараас их засварын ажил хийгдэж, номын сангийн стандарт шаардлагад нийцсэн тавилга эд хогшил, компьютер техник тоног төхөөрөмж суурилуулсан. Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан 2019 оны 02 дугаар 07, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сан 2019 оны 03 дугаар 06-ны өдрөөс уншлага үйлчилгээгээ эхлүүлсэн. Мөн төв номын сангийн Хүүхдийн уншлагын танхимд Арабын нэгдсэн Эмират улсын дэмжлэгтэйгээр 2019 оны 09 дүгээр сараас эхлэн иж бүрэн засвар, тохижилтын ажил хийгдэж, 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр нээлтээ хийн үйлчлүүлэгчдээ хүлээн авсан.

3. Тус номын сангаар үйлчлүүлэгчдийн дийлэнх хувийг оюутнууд эзэлдэг. Сүүлийн жилүүдэд их дээд сургуулиуд шинэ барилга барьж, номын сан хөмрөгтөө анхаарах болсноор үйлчлүүлэгчдийн тоо буурахад хүрч байна. Номын сан барьсан ИДС-иудаас дурдвал, ШУТИС, МУБИС, МУИС, ЭМШУҮИС гэх мэт.

4. Төв номын сангийн чөлөөт сонголттой уншлагын А, Б танхимын 38000 номд RFID мэдээллийг оруулж, номын ялтас наасан. Нийт ажлын 64 өдөр зарцуулсан.

### **3.3. Солилцоо болон зөөврийн үйлчилгээ**

Номын сангийн тухай хууль болон БСШУ-ы Сайдын 2010 оны 570 дугаар “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал” тушаалын дагуу **32** удаа **2023** ширхэг номоор 2500 гаруй хүнд хүргэлээ.

- Багануур дүүргийн Соёлын ордны номын сантай 1 жилийн зөөврийн уншлага хийх гэрээтэй ажиллаж 74 нэрийн номоор нийт 2 удаа,
- Нийслэлийн 380 жилийн ойд зориулан алслагдсан дүүргийн Гачуурт тосгоны 85-р сургуулийн 4в ангийн сурагчдад АХА тэмцээн зохион байгуулахад зориулж, Нийслэлийн түүх соёлын тухай 20 нэрийн номоор 1 удаа,

- 429-р хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт 22 нэрийн номоор 1 удаа,
- Хууль зүйн үндэсний хүрээлэнд 14 нэрийн номоор 1 удаа,
- ШШГЕГ-ЫН харьяа хаалттай хорих 411-р ангид 100 ширхэг номыг 1 удаа,
- Иргэдийн амралт, аялалын цагаар Улаанбаатар- Сүхбаатар- Байгаль нуурын чиглэлд зохион байгуулагдсан аялалд “Зуны уншлага- 365” 100 ширхэг номоор 1-удаа
- 1 дүгээр сарын 4-5 нд “Оюунлаг төрийн албан хаагч” аянаар Улаанбаатар-Чойр өртөө хүртэл УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэгийн санаачилсан “Номтой галт тэрэг” төслийн хүрээнд зөөврийн номын сангийн үйлчилгээг УБТЗ-ын ажилтан албан хаагчид болон зорчигчдод дэлхийн болон монголын сонгодог яруу найргийн 36 ширхэг номоор 1 удаа,
- Хан-Уул дүүргийн 13-р хороонд байрлах Зэвсэгт хүчний 120 дугаар цэргийн ангийн 100 албан хаагч, байлдагчдад "Зөөврийн номын сан"-гийн үйлчилгээг 74 ширхэг номоор 2 удаа,
- Баянгол дүүрэг дэх “Вербист” хүүхдийн асрамжийн төвийн 35 хүүхдэд 30 ширхэг номоор 1 удаа,
- Хан-Уул дүүргийн 13-р хороонд байрлах Зэвсэгт хүчний 326 дугаар цэргийн ангийн 83 албан хаагч, байлдагчдад 50 ширхэг номоор,
- Идэр Их сургуульд 5 удаа 160 ширхэг номоор,
- Хан-Уул дүүргийн ЕБ-ын 10-р сургуульд 50 ширхэг номоор 1 удаа
- Ерөнхий боловсролын 58-р сургуульд 40
- Сүхбаатар дүүргийн 1-р сургуульд 45 ширхэг номоор гэх мэт номоор,



#### **Номын сан хоорондын ном солилцоогоор:**

**14 удаа 935 номоор номын сан хооронд түр солилцоо хийжээ.**

- Их засаг Олон улсын их сургуулийн номын сантай хамтран 30 ширхэг номоор,
- Идэр дээд сургуулийн номын сантай 58 ширхэг номоор,
- Шинэ Иргэншил дээд сургуулийн МСҮТ-д 30 ширхэг номоор,
- Отгонтэнгэр их сургуультай 32 ширхэг номоор,
- Улаанбаатар хотын музейтэй 4 ширхэг номоор,
- Алслагдсан дүүрэг Багахангай дүүргийн Соёлын ордны нийтийн номын сантай 2 дахь жилдээ 24 номоор
- Өргөө амаржих газрын номын сантай 35 ширхэг номоор
- Ач АУДСургуулийн номын сантай 110 ширхэг номоор,
- Зохиомж дээд сургуулийн номын сантай 40 ширхэг номоор,
- Шилдэг дунд сургуулийн номын сантай 35 ширхэг номоор,
- СУИС-ийн Театр урлагийн сургуулийн номын сантай 21 ширхэг номоор,

- СХД-н Ерөнхий боловсролын 107 дугаар сургуульд 50 ширхэг номоор,
- СХД-н Ирээдүй цогцолбор 86 дугаар сургуульд 42 ширхэг боть номоор,
- СХД-н Ерөнхий боловсролын 81 дүгээр сургуульд 12 ширхэг номоор,
- "Хайрын билэг" хүүхдийн зусланд 20 ширхэг боть ном гэх мэт.

### 3.4. Интернет үйлчилгээ


Төв номын сан, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргүүдэд тус бүрт уншигч нарт зориулсан WiFi утасгүй интернетийн үйлчилгээг үнэ төлбөргүй, харааны бэрхшээлтэй иргэд болон олон нийтэд зориулсан 33 ш компьютерийг өдөрт 1 цаг үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг олгосон. ЧД, БЗД, СХД дэх салбар номын сангуудын интернетийг Ситинэт ХХК-ны 2Mbps dedicated хурдаар шилэн кабелийн гэрээ байгуулсан.

БЗД, СХД дэх салбар номын сангуудад засвар орсон тул шинээр байгууллагын сүлжээ зохион байгуулсан.

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернетийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 71.82 Mbps, дунджаар 3.38 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 64.45 Mbps, дунджаар 374.13 Kbps хүрсэн байна. Тайлангийн хугацаанд суурин интернетийг 17443 хэрэглэгч, утасгүй интернетийг 7261 хэрэглэгч ашиглаж, нийт 24684 хэрэглэгчид интернетийн үнэгүй үйлчилгээ үзүүлсэн. Төв болон салбар номын сангуудын интернет үйлчилгээ хэвийн жигд явагдаж байна.

### 3.5. Фондын бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтын талаар

2019 оны жилийн эцсийн байдлаар 663 нэрийн 1600ш 32,552,267.08 төгрөгийн тендерийн шинэ ном, 83 нэрийн 289ш 5,575,700 төгрөгийн хандивын ном, 154 нэрийн 175ш 2,221.150 төгрөгийн төслийн ном, 59 нэрийн 59ш 570,500 төгрөгийн төлбөрийн ном, 36 нэрийн 185ш 4,613,000 төгрөгийн номыг худалдаагаар тус тус бүрдүүлэн авч, АСМТ-ийн 76 нэрийн 101 ширхэг гадаад ном, нийтдээ 2464 ш номонд техник ажиллагаа хийж, 1126 нэрийн 2464ш номын мэдээллийг электрон каталогт оруулан, 2464ш баркод хэвлэсэн байна. Бүрдүүлэлтээр авсан бүх номыг Олон нийтэд үйлчлэх тасаг, салбар номын сангуудад хүлээлгэн өгч уншлагад шилжүүллээ.





Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан БСШУСЯ-ны албан ёсны эрхтэйгээр ЕБС-ийн 1-9-р ангийн 50 нэрийн сурах бичиг, 5 нэрийн бусад шинжлэх ухааны, нийтдээ 55 нэрийн 6,565,000 төгрөгийн номыг Е-PUB хүртээмжтэй форматаар тусгай хэрэгцээт боловсролын шаардлагад тохируулан бүтээж бүрдүүлээ.



“Хүртээмжтэй форматын Е-PUB цахим ном бүтээх чадавхийг нэмэгдүүлэх” олон улсын 4 өдрийн сургалтыг амжилттай зохион байгуулсан. Сургалтанд МУҮНС, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Хараагүй хүмүүсийн Инноваци хөгжлийн төв, МУИС, МУБИС, СУИС-ийн номын сан, МХҮХ, ХБ-тэй хүүхдийн 116-р сургууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Дорнод аймгийн нийтийн номын сан, Сүхбаатар аймгийн Хараагүйчүүдийн холбооны салбар зөвлөлийн төлөөллүүд болох нийт 24 хүн оролцлоо.

Дээрх сургалтыг өргөжүүлэн дотооддоо Е-PUB хүртээмжтэй форматын ном бүтээх цуврал сургалтуудыг 3 удаа Сүхбаатар аймгийн нийтийн номын сан, СУИС-ийн Соёлын сургуулийн оюутнууд, Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан дээр нийт 56 хүн хамруулан зохион байгуулж, холбогдох гарын авлагыг боловсруулсан.





Дэлхийн олон оронд хараагүй хүмүүсийн өргөн хэрэглэдэг "NVDA" компьютерийн дэлгэц уншигч програм хангамжийн монгол хувилбарын нээлтийн үйл ажиллагааг 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа.

"NVDA" програмыг компьютер, таблет зэрэгт суулгаж ашигласнаар Microsoft Office, Firefox, Google Chrome, Web Browser, mail, Social media, онлайн банк, интернет, телевиз, онлайн худалдаа гэх мэт бид бүгдийн түгээмэл хэрэглэдэг аппликэшнүүдийг саадгүй ажиллуулах боломжтой юм.



2019 оны 10 дугаар сараас “Хүртээмжтэй технологиор дамжуулан хараагүй хүмүүсийн мэдээлэл хүртэх боломжийг нэмэгдүүлэх” зорилт бүхий CANADA сан, Хараагүй хүмүүсийн инноваци хөгжлийн төв ТББ, Улаанбаатар хотын нийтийн төв номын сантай хамтран “Харааны бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл харилцааны шинэ технологиор дамжуулан чадавхжуулах нь төсөл”- ийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн нийтийн номын сан, ХУД дэх салбар номын санд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээг шинээр нээж, нийтдээ иж бүрэн компьютер 4ш, цахим брайль төхөөрөмж 4ш, дэйзи цахим ном тоглуулагч 4ш, скайнер 2ш, утасгүй интернетийн төхөөрөмж 2ш, чихэвч 4ш, PC яригч 4ш, ширээ 4ш, сандал 4ш зэрэг эд хөрөнгийг хүлээлгэн өгсөн. Мөн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой технологийн сургалтуудыг номын санч нарт болон харааны бэрхшээлтэй иргэдэд тус тус зохион байгуулсан.





Тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, энэ онд төвлөрсөн номын сангийн хэмжээнд 25 нэр төрлийн 4,265,700 төгрөгийн хэвлэл захиалан уншигчдад үйлчилж байна.

Коха програм руу хөрвөсөн үндсэн фондны болон А танхимын 752 нэрийн 4837 ширхэг номын каталогийн мэдээлэлд засвар хийсэн. 2017 онд фондноос хасахаар НӨХГ-аас шийдвэр нь гарсан 5900 гаруй ном хэвлэлийг данс бүртгэл болон каталоогоос хаслаа.

МХҮХ-той брайль болон цахим ном нийлүүлэх гэрээ байгуулах гэрээг байгуулж, энэ онд 50 нэрийн дэйзи номыг гэрээгээр хүлээж авлаа.

2018 оны судрын тооллогоор дутагдсан 196 ширхэг судар номыг үнэлэх ажлыг холбогдох газруудаар явж судалгаа хийсний үндсэн дээр үнэлж дүнг гаргасан.

***Лавлагаа, номзүйн үйлчилгээ***

Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааны цахим болон утсаар, амаар нийт **4935** удаа лавлагаа өгсөн байна.



## Номзүй

- Дорнын их яруу найрагч Б.Явуухулангийн 90-н жилийн ойд зориулсан намтар ном зүйн гарын авлага,
- С.Буяннэмэхийн зохиол бүтээлээр,
- “Үндсэн хууль”-ийн 95 жилийн ойд зориулсан санамж өгөх ном зүй,
- Монгол-Зөвлөлтийн цэрэг дайчид Халх голын дайнд ялалт байгуулсны 80 жилийн ойд,
- Монголын тамирчид Олимпод оролцож эхэлсний 55 жилийн ойд,
- Нийгэм улс төрийн холбогдолтой нийт 6 нэрийн санамж өгөх ном зүйн бүртгэлийг эмхэтгэн гаргалаа.



Ном зүйн гарын авлагыг хийхээс гадна 2008-2018 оны тогтмол хэвлэлийг өгүүллийн нэгдсэн санд оруулах ажлыг үргэлжлүүлэн хийж байна. Одоогийн байдлаар Улаанбаатар таймс сонинг Үндэсний тогтмол хэвлэлийн мэдээллийн санд оруулж байна.



### 3.1.6. Ном хэвлэл сэлбэн засах

Урагдаж гэмтсэн нийт **1966** ш номыг хэвлэлтийн анхны жинхэнэ хэлбэр байдлыг алдагдуулахгүйгээр сэлбэн зассан байна. Үүнд:

- Сэлбэн засагч 670 ш ном
- Төв номын сан 933 ш ном
- ЧД дэх салбар номын сан 80 ш ном
- ХУД дэх салбар номын сан 138 ш ном
- БЗД дэх салбар номын сан 83 ш ном
- СХД дэх салбар номын сан 142 ш ном тус тус сэлбэн зассан байна.

Төв болон салбар номын сангуудын тогтмол хэвлэлүүдийг нийт 310 нэгж, жижүүрийн дэвтэрийг 36 нэгж болгон тус тус хавтасласан байна.

### 3.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ/-ийн мэдээллийн үйлчилгээ

#### Ярьдаг номын сангийн уншлага, үйлчилгээ

Тайлант хугацаанд 1177 ирцэд 1483 ном олгож үйлчилсний 392 номыг танхимаар, 965 номыг гэрээр, 39 номыг солилцоогоор, 87 номыг зөөврөөр тус тус олгож үйлчилсэн байна.

Харааны бэрхшээлтэй иргэдэд 235 удаа лавлагаа өгсөн. Үүнд: Амаар 159, утсаар 75, мессенжерээр 1 удаа тус тус өгсөн байна.




Koica олон улсын байгууллагаас зохион явуулдаг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих сургалтын 50 ширхэг гарын авлагыг брайль бичигт хөрвүүлж холбогдох байгууллагуудаар тарааж хэрэглэгчдийн хүртээл болгосон.

“Номын далайд хамтдаа аялъя” уулзалт, чөлөөт ярилцлагыг 4 удаа зохион явууллаа. Үүнд:

“Тархи цэнэглэгч” номын клубыг үндэслэгч Ч.Идэрболд - 20 уншигч



116-р сургуулийн 5”А” ангийн сурагч М.Сод-Эрдэмтэй “Английн алдарт зохиолч Жек Лондоны уран бүтээл” - 3-5-р бүлгийн 20 сурагчид




Идэвхтэн уншигч С.Отгонбаатартай “Номын далайд хамтдаа аялъя” уулзалт, чөлөөт ярилцлагыг “Алтан товч” номоор зохион явууллаа. Уулзалтанд 11 уншигч хэрэглэгч оролцлоо.



МУБИС-ийн нийгэм хүмүүнлэгийн ухааны их сургуулийн, түүх нийгмийн ухааны багшийн 2-р дамжааны оюутан Т. Эрхэстэй “Г.Сүхбаатар Монголын эртний өвөг” номоор чөлөөт ярилцлагыг зохион явууллаа. Нийт 15 уншигч хэрэглэгч оролцлоо.

UB comedy клубыг үндэслэгч Б.Батбилэгтэй уулзалт зохион байгуулсан. Уулзалтанд 15 уншигч хэрэглэгч оролцсон байна.



Нийслэлийн 380 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар музейн эрдэм шинжилгээний ажилтан Э.Очбаяртай уулзалт зохион байгууллаа. Нийт 10 уншигч оролцсон.

LEC төвийн багш С.Ариунтуяатай “Уламжлалт аргаас татгалзаж, англи хэл сурах, бие хүний хөгжлийн талаарх” зөвлөгөө уулзалт зохиосон. Нийт 10 уншигч хэрэглэгч оролцсон.



Уншигч хэрэглэгчдийн хэрэгцээнд тулгуурлан “Англи хэлний ярианы клуб”-ын хичээлийг 10 удаа зохион явуулж, 55 уншигч хэрэглэгч оролцсон байна. Сургагч багш англи хэлний багшаар Л. Уртнасан ажилласан.



Улаанбаатар хотын 380 жилийн ойд зориулсан АХА тэмцээнийг уншигч залуусын дунд явуулж, 1-р байрт идэвхтэн уншигч МСҮС оюутан Тэмүүжин, 2-р байрыг МСҮС-ийн багш Ариун-Эрдэнэ нар эзэлсэн байна.

Хүүхдийн зохиолч О.Сундуйтай уран бүтээлийн уулзалт зохион явуулсан. 116-р сургуулийн бага бүлгийн сурагчдад нийт 70 хүүхэд багачууд оролцсон байна.



“Эссэ хэрхэн бичих” талаар сургалт зохион явууллаа. Нийт 15 уншигч хэрэглэгч оролцлоо. Сургагч багш Г. Гончигдорж.

Уншигч хэрэглэгчийн хэрэгцээнд тулгуурлан компьютерын ганцаарчилсан сургалтыг зохион явуулсан байна. Сургагч багш Гончигдорж суралцагч Гандрист нийт 40 удаагийн сургалт явагдсан байна.

“Улаанбаатарчууд уншиж байна” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан Дэлхийн номын баярын хүрээнд брайль номын үзэсгэлэнг 45 номоор, цахим номын үзэсгэлэнг 50 номоор тус тус гарган сурталчилсан.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 2 удаа 42 брайль болон цахим номоор гаргаж сурталчлав.



Тэргүүний уншигч шалгаруулах “Д.Нацагдорж тэмдэг”-ийн болзолыг ХБ-тэй хүүхдийн 116-р сургуулийн 5”А” ангийн сурагч Б.Сод-Эрдэм хангаж, тэргүүний уншигчийн тэмдэг үнэмлэхээ гардан авлаа.



Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэр дээр 11 удаа 57 хүнд 84 номоор зөөвөр уншлага, Налайх дүүргийн СО-ны номын сантай 10 удаа 31 брайль номоор солилцоо хийж хамтарч ажиллалаа.

Хүртээмжтэй хэлбэрийн 50 нэрийн цахим номын цаасан каталогийг брайль болон томруулсан форматаар хэвлэж үйл ажиллагаандаа ашиглаж байна. МУ-ын Газрын зурагт брайль тэмдэглэгээ хийж уншигч хүүхэд багачуудын хүртээл болголоо.

ХБИ-ийн фэйж хуудсуудаар дамжуулан уншигчдын эрэлт хэрэгцээг тогтмол судлан номын сангийн үйл ажиллагааг сурталчлан 5 удаа мэдээлэл оруулсан.

#### **Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан DAISY төв**

Монгол хэлний ярьдаг програм суулгах, тохируулах 22 удаагийн заавар зөвлөлгөө, NVDA дэлгэц уншигч компьютерийн програм ашиглах зааврын талаар 19 удаагийн зөвлөмж, цахим брайль төхөөрөмж ашиглах 14 удаагийн зөвлөмж, цахим ном тоглуулагчийг ашиглах 10 удаагийн зөвлөмж буюу 2019 онд нийт 65 удаагийн мэдээлэл харилцааны технологийн зөвлөмж өгч үйлчилсэн.

"Туслагч технологийн сургалт"-ыг 5 удаа зохион байгуулж, нийт 210 хүн хамрагдсан. Үүнд:

- Дэлхийн брайлийн өдөрт зориулсан үйл ажиллагааны хүрээнд цахим брайль төхөөрөмж танилцуулах сургалт - 80 хүн
- Дэлхийн номын өдөрт зориулсан үйл ажиллагааны хүрээнд DAISY ном тоглуулагч төхөөрөмж, цахим брайль төхөөрөмж танилцуулах сургалт - 116-р сургуулийн 30 гаруй хүүхдүүд эцэг эхийн хамт
- ХБ-тэй хүүхдийн 116-р сургуулийн 1-5-р ангийн сурагчдад зориулан DAISY цахим ном тоглуулагчийн сургалт - 70 гаруй хүүхдүүд багш нарын хамт
- ХБ-тэй хүүхдийн 116-р сургуулийн 6-12-р ангийн сурагчдад зориулсан сургалт – 30 хүүхэд
- Сүхбаатар аймгийн нийтийн номын сан дээр хүртээмжтэй технологийн сургалт – 42 хүн

- Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан - 3 номын санч



“Туслагч технологийн сургалт”-ыг ганцаарчилсан байдлаар Б.Мөнгөнтүшиг, М.Сандуйжав, М.Сод-Эрдэм, Э.Дөлгөөн нарын хүүхдүүдэд тус тус 11 удаа, нийт 36 удаа зохион явуулсан.

Уншлага үйлчилгээнд ашиглагдаж байгаа компьютер, DAISY ном тоглуулагч брайль принтер болон бусад техник хэрэгсэлүүдийн нийт 4 удаагийн саатал доголдлыг тухайн цаг бүрт нь засварлаж ажилласан.

2019 оны 2-р улирлаас эхлэн уншлага үйлчилгээний цахим ном уншигч төхөөрөмжийн тоо ширхэгийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 5 тоглуулагч үйлчилгээнд ор уулах бэлтгэл ажил эхэлсэн бөгөөд шинэ төхөөрөмжинд монгол хэлний ярьдаг програм суулгаж тохируулах, гарын авлага орчуулах зэрэг ажлууд 100% хийгдэж дууссан.



Монгол хэлний ярьдаг програмын 3 удаагийн шинэчлэл, NVDA дэлгэц уншигч програмын 4 удаагийн шинэчлэлт, компьютер форматлах, шинээр програм хангамжийг суулгаж тохируулах 14 удаагийн ажил тус тус хийгдсэн.

“Харааны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний албан ёсны facebook хуудсанд 30 удаагийн мэдээ мэдээлэл оруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний мэдээллийн “youtube” сувагт 40 удаагийн дүрстэй мэдээлэл оруулсан.

### 3.1.8. Мэргэжил аргазүйн үйлчилгээ

Зэвсэгт хүчний жанжин штабын Иргэн-цэргийн харилцааны хэлтэс, Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газартай хамтран “Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын номын санч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэдлэг мэдээллээр хангах, номын сангийн үйл ажиллагааны заавар”-ыг хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сургалтыг нийт 38 номын санчдын дунд 2019 оны 02 дугаар сарын 25, 26-ны



өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд тасгийн эрхлэгч З.Төгсжаргал “Номын сангийн фонд буюу сан хөмрөгийн тухай ойлголт”, “Номын сангийн ангилал” сэдвээр, каталогич Н.Одхүү “Номын сангийн каталог” сэдвээр онолын хичээл, ном ажиллагч М.Мөнхзаяа “Номын техник ажиллагаа”-ны, ном сэлбэн засагч Ц.Одсүрэн “Ном сэлбэн засах арга, ажиллагаа” чиглэлээр тус тус дадлага хичээлийг заалаа.



“Туслагч технологийн сургалт”-ыг ганцаарчилсан байдлаар харааны бэрхшээлтэй Б.Мөнгөтүшиг, М.Сандуйжав, М.Сод-Эрдэм, Э.Дөлгөөн нарын хүүхдүүдэд тус тус 7 удаа нийтдээ 28 удаа зохион явуулсан.



“Номоо өөрсдөө сэлбэн засацгаая” сэдэвт ном сэлбэн засах анхан шатны сургалтыг хүүхдүүд болон сургалт авахыг хүссэн хэн бүхэнд нээлттэйгээр зохион байгуулсан.



Нийслэлийн алслагдсан дүүрэг болох Налайх дүүргийн соёлын ордны номын санч Булганд номын данс бүртгэл, ном ангилал арга зүй, каталогжуулалт, техник ажиллагаа сэдвээр тус тус арга зүйн зөвлөгөөг өгч ажиллалаа.



2019 оны 03 дугаар сар 13-ны өдөр Сүхбаатар аймгийн Нийтийн номын сангийн номын санчид тус тасгийн үйл ажиллагаатай танилцаж, цахим үйлчилгээний талаар шинэлэг мэдээлэлүүдийг авч харилцан санал бодлоо чөлөөтэй солилцлоо.



Монгол Улсын Төрийн гурван удаагийн шагналт, Ардын уран зохиолч, ХХ зууны манлай соён гэгээрүүлэгч Цэндийн Дамдинсүрэнгийн нэрэмжит Дорнод аймгийн төв номын санд “НОМЫН САНЧДЫН БҮТЭЭЛЧ ХАНДЛАГА” сэдэвт сургалтыг 2019 оны 05 дугаарын сарын 21, 22-ны өдрүүдэд зохион явууллаа.

Сургалтанд Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн НБТҮТ-гийн эрхлэгч З.Төгсжаргал "Цахим номын E-Pub формат", "Номын сангийн ББК ангилал, ном ангилах арга зүй", "Зохиогчийн эрхийн хууль"-нд шинээр орсон нэмэлт өөрчлөлт сэдвээр хичээл заалаа.


Сургалтанд аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургууль, Сумдын нийтийн номын сан болон сургуулийн номын сан, Дорнод Их сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ХЦ-ийн 0132-р анги зэрэг нийт 40 гаруй номын санчид хамрагдав.



Дэлхийн номын баярын өдрийг тохиолдуулан ОНҮТ, НБҮТ-аас нийслэлийн алслагдсан дүүрэг болох Багахангай, Багануур дүүргийн соёлын ордны номын сан болон Багануур дүүргийн 5-р хорооны "Номын өргөө" - Иргэний танхимын номын сан, "Оюуны эрин" цогцолбор сургуулийн номын сангуудад 2019 оны 4-р сарын 19, 20-ны өдрүүдэд очиж ажиллалаа. Дээрх номын сангуудад зөөврийн номын сан ажиллуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Мөн Багануур дүүргийн 5-р хорооны "Номын өргөө -Иргэний танхим"-ын номын санд 200 гаруй ном хандивлалаа. Энэ арга хэмжээнд НБҮТ-ийн эрхлэгч З.Төгсжаргал, ном зүйч О.Долгорсүрэн, номын санч Г.Баяржаргал, Д.Дэлгэрсайхан нар хамтран ажиллалаа.



СУИС-ийн Соёлын сургуулийн Номын сан судлалын ангийн эчнээ зайн сургалтын болон 2,3-р курсын 6 оюутны “Үйлдвэрлэлийн дадлага”-аар Номын нэгдсэн болон нэгбүрчилсэн бүртгэлүүдийн хөтлөлт, номын каталогжуулалт, ном ангилал арга зүй, номын техник ажиллагаа, ном бүрдүүлэлт, ном сэлбэн засах чиглэлээр сургалтуудыг өгч ажиллалаа.



### 3.2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар

3.2.1. Сар бүрийн сүүлийн 7 хоногийн Мягмар гараг бүрийн Дотоод ажлын өдрүүдэд номын сангийн ажилтнууддаа зориулсан сургалт, уулзалт, тэмцээн зохион байгуулж ажилласан. Тухайлбал:

- Захирал Д.Индра “Харилцааны ёс зүй” сэдвээр
- Олон нийтэд үйлчлэх тасгийн эрхлэгч В.Түвшинтогтох “Сэтгэлгээний онцлогоо тодорхойлон суралцах арга барилаа сонгох нь” гэсэн сэдэвт онол, практик хослосон сургалт
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн сургагч багш Оюун-Эрдэнэ “Төрийн албаны тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль” сэдэвт сургалт
- “Багийн бүтээлч ажиллагаа, Хэрхэн хандлагаа зөв удирдах вэ?” сэдэвт 1 сая төгрөгийн өртөг бүхий сургалтыг Иргэний нийгмийн байгууллагатай хамтран, үнэ төлбөргүйгээр зохион байгууллаа.
- Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд Монголын Үндэсний Номын Сангаас зохион явуулсан “Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах арга зүйн зөвлөмж” сэдэвт сургалтанд номзүйч О.Долгорсүрэн, ахлах номын санч Г.Баяржаргал нарыг хамрууллаа.
- БСШУСЯ-ны хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар, Богд хааны ордон музей хамтран зохион байгуулсан “Сэргээн засварлалтын түүх, хөгжил, орчин үеийн сэргээн засварлалтад ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжүүд”, “Тайваны үндэсний хааны ордон музейд ашиглагдаж буй сэргээн засварлалтын тоног, төхөөрөмжүүд” гэсэн сэдэвт сургалтад номзүйч О.Долгорсүрэнг хамрууллаа. Сургалтыг Тайваны үндэсний хааны ордон музейн Бүртгэл, сэргээн засварлалтын хэлтсийн ахлах сэргээн засварлагч Chen ро удирдан явууллаа.
- Монголын Улсын Хөдөлмөрийн Яамнаас зохион явуулсан МСҮТ-ийн номын санчдад зориулсан сургалтад тасгийн эрхлэгч В.Түвшинтогтох “Номын санчийн бүтээлч хандлага”, “Номын сангийн мэдээллийн сан”, “Судлаач номын санч” сэдвүүдээр сургалт зохион байгууллаа. Мөн Багшийн мэргэжил дээшлүүлэх Институтээс анхны жилдээ ажиллаж буй ЕБС-ийн номын санчдад зориулан “Номын сангийн каталог зохион байгуулалт” сэдвээр сургалт хийлээ.
- БСШУСЯамны хэрэгжүүлэгч агентлаг Соёл, Урлагийн Газрын захиалгаар Монголын Номын Сангуудын Консорциумаас зохион явуулсан “Мэдээллийн технологи ба номын сан” сэдэвт 14 хоногийн сургалтыг Улаанбаатар хотын нийтийн төв номын

санд зохион байгуулж “Цахим мэдээллийн бүрдүүлэлт, зохион байгуулалт, хадгалалт” сэдвээр тасгийн эрхлэгч В.Түвшинтогтох хичээл заасан.

- Номын санч Б.Шүрэнбагана, Номзүйч О.Долгорсүрэн нар Сүхбаатар аймагт “Номын сангийн шинэлэг үйлчилгээ, түүнийг хэрэгжүүлэх нь” сэдвийн хүрээнд сургалт зохион байгууллаа. Мөн Дорнод аймгийн номын санчдад "Номын санчдын бүтээлч хандлага" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Эдгээр сургалтуудад нийт 60 гаруй номын санч хамрагдлаа.


3.2.2. Номын сангийн менежер карьер институт Доржи Банзаровын нэрэмжит Буриадын их сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд 2 дахь жилдээ зохион байгуулж буй Байгалийн олон улсын зуны сургалтанд боловсон хүчний менежмент сургалтад номын санч Х.Сарантуяа, Б.Шүрэнбагана нар хамрагдаж тус сургуулийн номын сангийн үйл явцтай танилцаж, туршлага судлаад ирсэн. Мөн АНУ-ын элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр Автрали улсын Вена хотод Америк Соёл мэдээллийн төвийн чиглэлээр Б.Шүрэнбагана, Ц.Байгалмаа нар 10 хоног сургалтад хамрагдсан.

3.2.3. Тус номын санд 3-аас дээш жил ажилласан, мэргэжил шаардсан 37 албан тушаалд одоо ажиллаж байгаа ажиллагсдын 36 нь буюу 97,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

3.2.4. 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийслэл, Соёл, урлагийн газар болон бусад байгууллагуудын шагналд нийт 23 ажилтнуудыг тодорхойлж нэр дэвшүүлэн холбогдох байгууллагад хүргүүлсэн. Үүнээс 14 ажилтан холбогдох шагнал хүртсэн.

3.2.5. Одоо ажиллаж байгаа ажиллагсдын 52% буюу 33 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгож, 5 ажилтны цалингийн шатлалыг ахиулсан. Ажилтан бүрт сар бүр хоол унааны мөнгө 60.000 төгрөг олгодог.

3.2.4. Захиргаа, ҮЭ-ийн хорооны хооронд байгуулсан Хамтын гэрээний дагуу байгууллагын 55 ажилтныг Хавдар судлалын үндэсний төвийн эмнэлэгт урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.



Мөн нийт албан хаагчийг томуу, томуу төст өвчлөл, тоосны харшлаас сэргийлэх, дархлаажуулах зорилгоор витаминжуулалтын аянг зохион байгууллаа.

### 3.3. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Тайлант хугацаанд 22 өргөдөл ирснийг бүртгэлийн дэвтрээр болон [www.erp.ulaanbaatar.mn](http://www.erp.ulaanbaatar.mn) цахим системд бүртгэн 100 хувь барагдуулж ажилласан. Хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 1 өргөдөл байна.

Нийт өргөдлийг агуулгаар нь авч үзвэл:




Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 22 цаг 14 минут байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацааг 2018 оныхтой харьцуулахад /2018 оны 11 хоног 19 цаг 50 минут/ 4 хоног 9 цаг 30 минутаар буурсан байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам буюу 4 удаа гаргаж НЗДТГазар руу хүргүүлж ажилласан. Байгууллагын удирдлага иргэдтэй хийсэн уулзалт байхгүй байна

## Дөрөв. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

### 4.1. Үйл ажиллагааны ил тод байдал:

Тус номын сангаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, уншигчаар бүртгүүлэх, гэрээр ном авахад шаардлагатай баримт бичиг, ажлын цагийн хуваарь, үйлчилгээний журам, дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, арга хэмжээний зар мэдээ зэрэг иргэдэд зайлшгүй шаардлагатай 47 холбогдох мэдээ, мэдээллийг [www.pl.ub.gov.mn](http://www.pl.ub.gov.mn) цахим хуудсаараа мэдээлсэн.



Номын сангийн захирлын 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн “Төлбөрт үйлчилгээний үнийг шинэчлэх батлах тухай” А/01 дүгээр тушаалыг, үйлчилгээ авахад шаардах баримт бичгийн жагсаалт болон холбогдох мэдээллийг хамт ойлгомжтой байдлаар цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулсан байгаа. Номын сангийн тухай хууль, Номын сангийн үйлчилгээний журмыг уншигчдад ойлгомжтой байдлаар зурган болон видео бичлэгээр хийж вэб сайт, мэдээллийн самбар, нийгмийн сүлжээ, номын сангийн үүдэнд байрлах дэлгэцээр тус тус сурталчиллаа.

Номын сангийн эрхлэгч нарын овог нэр, албан тушаал, харилцах утас, ажиллах цагийн хуваарийн хамт цахим хуудсанд болон мэдээллийн самбартаа байршуулсан.

Номын сангаас зохион явуулж буй үйл ажиллагааны талаар ТВ9, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевиз, Гэр бүлийн радио, МОНЦАМЭ агентлаг зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудад ярилцлага, хэвлэлийн мэдээг өгч ажиллалаа.

Нийгмийн сүлжээг ашиглан номын сангаас зохион явуулж буй үйл ажиллагааны талаар шууд дамжуулалт буюу live-ийг 2 удаа зохион байгууллаа.

Соёл урлагийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож номын сангаас зохион явуулж буй үйл ажиллагааны талаарх 450 гаруй танилцуулга, мэдээллийг уншигчдад түгээлээ.

MakerSpace төвийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчилгааг олон нийтэд хүргэх үүднээс сошиал медиа ашиглан Фэйсбүүк хуудас шинээр нээсэн <https://www.facebook.com/makeuspacemongolia/> хуудсаар нийтдээ 316 удаагийн пост оруулж хамгийн шилдэг пост 11594 үзэгчтэй 169 реакци, 77 таалагдсан санал авсан тус постыг орууллаа. Тус хуудас органикаар 1453 дагагчтай, 1404 лайктай байна.

#### 4.2. Хүний нөөцийн ил тод байдал:

Номын сангийн цахим хуудасны нээлттэй ажлын байр цэсэнд сул орон тооны зарыг 10 удаа байршуулан тухай бүр шинэчилж байгаа. Үүнд: номын санч 1, үйлчлэгч 6, жижүүр 3.

### Тав. БУСАД МЭДЭЭЛЭЛ

#### 5.1. Соёл, олон нийтийн ажлын талаар

Төв болон салбар номын сангуудын хэмжээнд соёл, танин мэдэхүйн ажлуудаа Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Тайлант хугацаанд:

№	Үйл ажиллагааны нэр	2019	
		Давтамж	Хамрагдсан хүний тоо
1	Уулзалт лекц	78	4651
2	Уралдаан, тэмцээн	51	1598
3	Сургалт	81	3346
4	Чанга уншлага	31	944
5	Кино үдэш хөтөлбөр	33	530
6	Мультимедиа лаб үйлчилгээ		331
7	Ганцаарчилсан кино үйлчилгээ	73	325
8	Номын нээлт, хэлэлцүүлэг	17	916
9	Номын үзэсгэлэн	341	1927
10	Зөвлөмж яриа	37	487
11	Тойм яриа	22	598
	Нийт	<b>764</b>	<b>15653</b>

Эдгээрээс тоймлон үзвэл:

**Уулзалт, лекцийн чиглэлээр:**

- Улаанбаатар хотын хотын нийтийн төв номын сангаас сар бүр Д.Нацагдоржийн шагналт зохиолчидтой “Уулзалт, өдөрлөг” зохион байгуулдаг бөгөөд 2019 оны 1-сарын 15 ны өдөр Д.Нацагдоржийн шагналт зохиолч, яруу найрагч П.Нямлхагватай уулзалт хийсэн юм. Уулзалтын үеэр “Сэлүүн тэргэл”, “Тэнүүн дэлгэр” романы нээлтэнд зохиолчийн зохиол бүтээлүүдийн хямдралтай, гарын үсэгтэй номын худалдаа явагдлаа. Уулзалтанд 50 хүн хамрагдлаа.
- Дэлхийн яруу найргийн өдрөөр Номын сангаас зохион байгуулсан МЗЭ-ийн шагналт яруу найрагч Л.Мягмарсүрэнтэй хийсэн уулзалтанд МЗЭ-ийн зохиолч, яруу найрагчид, Соёл урлагийн их сургуулийн жүжигчний 2-р дамжааны оюутнууд болон БШУЯ-ны харъяа лаборатори 23 дугаар сургуулийн 65 сурагчид оролцлоо.



- 976 Арт Галлери-тэй хамтран 1-р сургуулийн 11, 12-р ангийн сурагчдад “Уран зургийн түүх ба ойлголт хөгжлийн үе шат” сэдвээр лекц явуулав. Нийт **250** хүүхэд оролцсон.
- БЗД-ийн 20-р хороо Гачуурт тосгоны 85-р сургуулийн 4-р ангийн сурагчдын дунд Д.Нацагдорж тэмдэгийн болзлыг танилцуулаад нэг жилийн хугацаанд хамгийн их ном уншсан сурагчдын номын тэмдэглэлтэй танилцаж, урамшуулж “**Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн**” шагналыг 3 хүүхдэд гардуулан өгч хүүхдүүдэд ном уншихын ашиг тусыг танилцууллаа.



- “Алаш Монголиа” ТББ-тай хамтран Яруу найрагч Х. Байыттай казак оюутан залуустай ярилцлага хийв. Уулзалтад 45 оюутан, залуус хамрагдлаа.
- Дэлхийн номын баярын өдрийг тохиолдуулан Хараагүй иргэдэд үйлчилдэг уншлагын танхимаас Хүүхдийн зохиолч О.Сундуйтай уулзалт өдөрлөгийг зохион байгуулсан ба 116-р тусгай сургуулийн сурагчид оролцсон .Тус өдөрлөгт 60 хүүхэд хамрагдсан.





- Газар дэлхий Бидний гэр Олон улсын хүүхэд залуучуудын 17-р их наадмын өдөрт зориулж Хөгжимчин Д.Энхболдтой уулзалт өдөрлөгийг хийсэн ба тус уулзалтанд 55 хүн оролцсон.
- АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр Монгол улсад ардчиллыг бэхжүүлэх манлайгчдын шинэ үеийг бэлтгэхэд чиглэсэн LEAD Mongolia 2019 хөтөлбөрийн танилцуулга лекц 1 удаа явагдаж 60 хүн хамрагдсан.
- Хариуцлагатай аялцгаая аяны хүрээнд Дэлхийгээр аялцгаая группын хамт олонтой хамтран “Хариуцлагатай аялцгаая” аяны цар хүрээг өргөжүүлэх, гадаадад зорчих иргэдэд албан ёсны мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг түгээх зорилгоор АНУ-н ЭСЯамны Консулын Албаны дэд дарга Jeniffer Upton-тай нээлттэй уулзалтыг зохион байгуулсан ба тус уулзалтад 108 хүн оролцсон.



- Дэлхийгээр Аялагчид Клубийн Уулзалт #18-аар Их зохиолч Д.Нацагдоржийн алс газар сурахаар одсон мөрийг мөшгөсөн "Найрагчийн мөрөөр" аялалын багийнхантай уулзалт зохион байгууллаа. Тус багийн хамт олон аялалд гарахынхаа өмнө Улаанбаатар хотын нийтийн төв номын сангаас их зохиолч Д.Нацагдоржийн намтар, уран бүтээлтэй холбоотой ном, материалуудыг авч ашиглан, заримыг нь аялалынхаа турш ашиглаж байсан юм.

ХАРИУЦЛАГАТАЙ АЯЛЦГАА АЯНЫГ ДЭМЖИГЧ

**Дэлхийгээр Аялагчид Клубийн Уулзалт #18**  
**“НАЙРАГЧИЙН МӨРӨӨР” АЯЛАЛ**

“НАЙРАГЧИЙН МӨРӨӨР” ТӨСЛИЙН АЯЛАГЧ  
**Н.Энхбат** (төслийн продюсер)  
**У.Бямбаням** (төслийг санаачлагч)  
**М.Төгөлдөр** (зураглаач)

**ХЭЗЭЭ: 2019.7.27-ний Бямба гараг 13:00 цагт**  
**ХААНА: Америкийн соёл мэдээллийн төвд**  
 Байршил: Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын төв номын сан

#ХариуцлагатайАялцгаая  
 #TravelResponsibly  
**TAX FREE**

- Монголын номын санчдын **Librarian Update-2019 зөвлөгөөнийг** Mongolian Libraries Consortium - Монголын Номын Сангуудын Консорциум, Соёл урлагийн их сургууль, UB Public Library - Хотын Төв Номын Сан, German Mongolian Institute for Resources and Technology - GMIT зэрэг байгууллагууд хамтран зохион байгууллаа. Зөвлөгөөнд 70 гаруй байгууллагын 110 гаруй номын санч мэдээллийн ажилтан хамрагдлаа.



- **Америкийн тухай цуврал лекцүүд:** Америк гэр бүл, мужууд, өмнөд зүгийн гар урлал, амралт чөлөөт цагийн талаар цуврал лекцүүд явагдлаа. Мөн 1973 онд Монгол, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох оролдлогыг тухай лекцүүд зохион байгуулагдлаа.



#### Уралдаан, тэмцээн:

- Нийтийн уншлагын “А” танхимын ахлах номын санч Г.Баяржаргал, номын санч Д.Дэлгэрсайхан нар Баянзүрх дүүргийн 85 дугаар сургуулийн н.Сувдаа багштай 4 б ангийн 31 сурагчдын дунд “Улаанбаатар хотын 380 жилийн ойд” зориулж “АХА” тэмцээн зохион байгууллаа.



- Үндэсний бичиг үсгийн баярыг угтан “Алтан үсгийн цоморлог-2019” уралдааныг 3 дахь жилдээ зохион байгуулж 10 гаруй материал хүлээн авч, эхний дөрвөн байрыг шалгарууллаа. Уг уралдааныг номын санч Х.Сарантуяа, Ж.Мөнхжаргал нар амжилттай зохион байгуулж байна.



- 4в ангийн 31 сурагчдад Д.Нацагдорж тэмдэгийн болзлыг танилцууллаад 1 жил болж байна. Энэ нэг жилийн хугацаанд хамгийн их ном уншсан сурагчдын номын тэмдэглэлтэй танилцаж, урамшуулж “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” шагналыг 3 хүүхдэд гардуулан өгч хүүхдүүдэд ном уншихын ашиг тусыг танилцууллаа.
- Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан фээсбүүк буюу нийгмийн сүлжээний “Үндэсний бичиг үсгийн баяр” хуудсаар шууд дамжуулан үзүүлсэн лайвыг хамгийн олон шэйр хийсэн, асуулт асуусан хүнийг номоор шагнах уралдааныг зарлаж, шалгарууллаа.
- МУИС-ийн дэргэдэх Утга зохиолын нэгдэлтэй хамтран “Чөлөөт сэтгэлгээний дуулал-2019” яруу найргийн наадмыг зохион байгууллаа. Наадамд 80 гаруй хүн хамрагдлаа. Идэр дээд сургуультай хамтран “Шинэ толь-2” улсын уралдааныг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Уралдааныг Монголын Үндэсний номын сан, ИИС-ийн Номын сан, Монгол уламжлал академийн хамтран зохион байгууллаа. Энэхүү уралдаан нь “уран бичлэг”, “яруу найргийн” гэсэн хоёр төрлөөр явагддаг бөгөөд 2019 оны 5 дугаар сарын 17-нд МУҮНС-ийн МУ-ын Ерөнхийлөгчийн нэрэмжит танхимд боллоо.



- “BOOK QUIZ” -номын таавар хөгжөөнт уралдаан тэмцээн уншигчдын зохион байгуулсан. Нийт 6 баг 17 уншигч оролцсон. Тэргүүн байранд Т. Маргад Д.Зөнбилэг, Х. Нинжин нар тэргүүллээ.



- Англи хэлний илтгэлийн клуб 7 удаа сургалт зохион байгуулж, сургалтын эцсээр уралдаан явуулж дүнгээ гаргалаа. Сургалт, уралдаанд нийт 109 хүн хамрагдсан байна.
- Ач АУИС-ийн 60 гаруй оюутан, 11-р сургуулийн 100 гаруй сурагчдын дунд АХА тэмцээн зохион байгууллаа.

### Сургалт:

- **“3D принтер ажиллуулах, Arduino төсөл хийх” сургалт:** Энэхүү сургалтыг 2 удаа зохион байгуулсан бөгөөд сургалтын зарыг олон нийтэд нээлттэй явуулснаас анхны сургалтанд 48 хүний материал ирснээс 2-р шатанд 28 сурагчийг ярилцлаганд оруулан анкетын аргаар судалгаа хийж сүүлийн шатанд 16 сурагчийг шалгаруулан сургалт амжилттай зохион байгуулсан. 2 дахь удаагийн сургалтыг дээрх журмаар явуулж танхимын хучин чадалтай холбогдуулан нийтдээ 12 хүүхдийг шалгаруулсан. Сургалт 2019.04.17-нд эхэлж сурагчид маань төгсөлтөндөө бэлтгэж өөрсдийн сургалтаас авсан мэдлэг чадвар дээр тулгуурлан шинэ бүтээлүүдээ хийж байна. Тус сургалтанд ЕБС-ын 7-12-р ангийн 13-16 насны сурагчид 7 хоногт 6 цагаар 8 долоо хоногийн Электроник, 3D загварчлал, Багийн ажиллагаа гэсэн сэдвүүдээр эрчимжүүлсэн сургалтанд хамрагдаж нийтдээ 27 хүүхэд амжилттай төгсөн сертификат гардан авсан. Эхний төгсөлтийн арга хэмжээ 2019.04.12-нд Хөтөлбөрийн танхимд явагдсан. Тус арга хэмжээнд АНУ-аас МУ-д суугаа элчин сайд Майкл Клечески, ХТНС-ын захирал Д.Индра нар оролцон төгсөгчдөд сертификат гардуулсан. Мөн арга хэмжээний МейкЮспэйс танхимын албан ёсны нээлтийг хийж нийт 60 гаруй хүн хамрагдсан байна.



- “My first English” англи хэлний анхан шатны сургалт 7 хоногт нэг удаа явуулж байна. Нийт 18 удаа бага ангийн **278** сурагчийг хамруулжээ.
- 3 дугаар сарын 13-нд Номын сан танилцуулах хэсэгчилсэн сургалтаар Сүхбаатар аймгийн нийтийн номын сангийн **7** номын санчид ажлын туршлага солилцох хөтөлбөрийн хүрээнд номын сангийнхаа тасаг нэгжүүдийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцуулж ажилласан.



- Англи хэлний багш нарт зориулагдсан англи хэлний заах арга зүйн сургалт 13 удаа явагдаж 249 хүн хамрагдсан.
- Англи хэлний илтгэлийн клуб 11 удаа зохион байгуулагдаж 393 хүн хамрагдсан.



- Хүүхдийг хамгаалах сангаас ЕБС-н сурагчдын дунд зохион байгуулсан Дэлхий залуу энтрепренер хэрхэн болох? Сургалт 1 удаа явагдаж тус сургалтанд 9 сургуулийн 65 сурагч хамрагдсан.
- Зориг сан Америкт Сургууль Төгсөгчдын Холбоотой хамтран “Сошиал Энтрепренер” сургалтыг нийгмийн салбар бүрийн идэвхитэй залуусыг хамруулан хийсэн ба тус сургалт 4 удаа зохион байгуулагдан 21 оролцогч хамрагдсан.
- Зориг сангаас Орон нутгийн байгаль орчны манлайлал хөтөлбөрийн хүрээнд нийслэл, орон нутгаас шалгарсан 21 оролцогч хамрагдсан тус сургалт 2 удаа явагдсан.



- Монголын 4 навч ТББ–с Аксес хөтөлбөрийн сурагчдад зориулан гарааны бизнесийн талаар болон , хэрхэн бизнес эрхлэх бизнесийн үнэ цэнэ гэж юу болох, бизнесийн ерөнхий ойлголтын талаарх сургалтыг Эерэг Нөлөө ТББ тай хамтран зохион байгуулсан. Уулзалт 1 удаа зохион байгуулагдаж 24 хүүхэдийг хамруулаад байна.



- ЕБС-н сурагчдад зориулсан Тоглоомын өдөр хөтөлбөр 2 удаа зохион явагдаж 56 хүүхэд хамрагдсан.
- ЕБС-н сурагчдад зориулсан Англи хэлний клубын хөтөлбөр 2 удаа явагдаж 77 хүүхэд хамрагдсан.
- Англи хэлний багш нарт зориулагдсан заах арга зүйн сургалт 2 удаа 75 оролцогч
- Англи хэлний туслах багш нарын сургалт 1 удаа 40 багш
- Англи хэлний илтгэлийн клуб 7 удаа зохион байгуулагдаж 109 хүн хамрагдсан.
- Монголын 4 навч ТББ–с Аксес хөтөлбөрийн сурагчидийн сургалт 1 удаа явагдаж 28 хүүхэд
- АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр Монгол улсад ардчиллыг бэхжүүлэх манлайгчдын шинэ үеийг бэлтгэхэд чиглэсэн LEAD Mongolia 2019 хөтөлбөрийн сургалт үйл ажиллагаа 4 удаа явагдаж 125 хүн
- Америкийн Монгол Судлалын Төвөөс зохион байгуулсан Хээрийн сургууль 2019 хөтөлбөрийн оролцогчидод зориулсан танилцуулга 2 удаа явагдаж 120 оролцогч



Байгаль орчинд ээлтэй дахин загварчлах, хуучин хувцас сэргээх, шинээр өөр хэрэгцээт зүйлсээ хийж сурах зорилготой оёдлын сургалтыг загвар зохион бүтээгч И.Урангоотой хамтран нийтдээ 17 удаа зохион байгуулж 141 хүн хамрагдсан байна. Сургалтын



зарыг олон нийтийн сүлжээгээр мэдээлж, арга хэмжээний хүрдэнд эвент үүсгэх, олон хэрэглэгчийг татахад анхаарч мөн үр дүнг олон нийтэд нээлттэй сурталчилсан. Мөн Нийслэл гайд сэтгүүлд мэдээлэл өгч ажиллалаа. Сургалтаар Даавууны өөдсөөр эко тор хийх, Бэлэг дурсгалын зүйл, Шил чимэглэх, Номын хавтас, Хуучин хувцасны загвараа өөрчлөх, Хувцас чимэглэх зэрэг хичээл орсон.

### Чанга уншлага:

- “Ухаалаг Монгол Хүүхэд” уншлагыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 149-цэцэрлэгийн дунд бүлгийн хүүхдүүдэд “Бумбардай” комик номоор чанга уншлага хийв.



- Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Сүхбаатар дүүргийн 214 цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 40 хүүхдэд “Унших дуртай болмоор байна” сэдвээр чөлөөт ярилцлага хийж номын сангаар хэрхэн үйлчлүүлэх тухай заавар, зөвөлгөө өгч, Х.К. Андерсоны үлгэрүүдээр чанга уншлага хийв.
- Хан-Уул дүүргийн 10-р сургуулийн н.Энхболор болон н.Чимэдмаа багштай 2<sup>б,в</sup> ангийн сурагчид, “Ана кушагы” өдөр өнжүүлэхэд “7 ишиг” үлгэрээр үлгэрчилсэн тоглолт болон чанга уншлага тус тус хийв.
- Нийслэлийн 40-р цэцэрлэгийн С. Цэцэгмаа багштай бэлтгэл бүлэгт “Номын сантай танилцъя” уулзалт болон “Миний дуртай үлгэрийн баатар” сэдвийн дагуу 40 хүүхэд чанга уншлага хийв. Чанга уншлагыг хүүхдийн уншлагын танхимын номын санч Ж.Рая амжилттай зохион байгуулж байна.



### Кино үдэш хөтөлбөр

1. Америкийн түүхэн сард зориулан гаргасан кино:
  - Morris From

**Re-Designed**  
 Насны ангилал: 3-  
 Сургалтын чиглэл:  
 Даавууны өөдсөөр дүүрэгтэй, дэр, цэцэг, хөвд, хуучин хувцсыг засварлан загвар өөрчлөх.  
 Тэд хуучин хувцсыг дэлгэн сэргээх, шинэлж хэв шинжтэй болгох, материалыг үндэрдэлгүй ашиглаж, эдийн засгаа хэмжээний сандуу байдалд ээлтэй зөв амьдрах хэв маягийг түгээхийг зорилгоо болгодог. Нийгмийн харууцлагатай, бүтээн хандлагыг бий болгохыг уриалдаг тэдний хаалга өөрийгөө дайчлан юмханаар юм хийж, шинэлж сэтгэхийг хүссэн хүн бүрийн өмнө нээлттэй. Та урьдчилан цаг өгч бүртгүүлээд үнэ төлбөргүй хамрагдварай.  
 9 Насарбаржийн замын сэнгийн 1 дэвдэрт  
 5, 9444-1179, 8018-2921  
 Re-Designed

- The Butler
  - Malcolm X
2. Эмэгтэйчүүдийн түүхэн сард зориулан гаргасан кино:
- Hidden Figures
  - Dark Girls
  - Pritty Woman
3. Дэлхийн өдөрт зориулан гаргасан кино:
- Avatar
  - The 11th Hour
  - Finding Nemo
  - Good Will Hunting
4. Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг угтан гаргасан кино:
- Mele Murals
  - The Legends of Jazz with
  - Forest Gump
  - The Lorax



#### Номын нээлт, хэлэлцүүлэг

- П.Нямлхагвын “Сэлүүн тэргэл”, “Тэнүүн дэлгэр”,
- Т.Мягмартогтохын “Дээд айл”,
- Б.Галаарид “Урианхай өргөжин тэлсэн түүх”,
- Д.Даваадулам “Оргил өөд”,
- Ш.Солонго “Хагацсан нутаг”,
- Л.Ганчимэг “Намайг өөрчилсөн 85 эмэгтэй”,
- А.Цэрэнчулуун “Цагаан сарнай”,
- Б.Баясгалан “Дур булаам”
- Н.Ваня “Мөнгөн өвс”,
- Я.Отгонбаяр “Гуч хүрсэн бүсгүй”,
- Г.Лхагвадорж “Сэтгэл бид хоёр”
- Вольф Дурианы “Хайрцагнаас гарч ирсэн Кай хүү”,
- Ж.Нарангарав “Тэнгэрийн хүлэг тахь”,
- Г.Отгонсүрэн “Аав орчлон” гэх мэт.






### Номын үзэсгэлэн

- Ховор номын үзэсгэлэн/15 ширхэг судар, Монгол бичгийн 6 ширхэг номоор/,
- Д.Сүхбаатарын мэндэлсэний 126 жилийн ойд 15 ном, өнгөт 28 зураг,
- Валентины өдөрт 28 ном,
- Март-8 Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалаах өдөр 31 ном,
- Наурызын баяр 33 ном,
- Ардын уран зохиолчдын зохиол бүтээлүүд 98 ном,
- Ю.А.Гагарины 85 жилийн ойд зориулан 28 номоор үзэсгэлэн,
- Дэлхийн номын баярын өдөрт зориулан 140-1960 аад оны хуучны мартагдсан 57ш номоор,
- Хүүхдийн эрхийн хамгаалах өдөрт зориулан 1950-1980 оны хүүхдийн 34 номоор,
- Дэлхийн тамхигүй өдөрт /5-р сарын 31/ зориулан хэв мат, болон 12 номоор,
- “Монгол Улсын үндсэн хуулийн өдөр”-т зориулан 15 ширхэг номоор,
- “Цагаан сар” үзэсгэлэн 18 ширхэг ном, 12 ширхэг хэвлэмэл материалаар,
- “Номын санч” сэдэвт үзэсгэлэн 25 ширхэг номоор,
- “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-т 19 ширхэг номоор,
- “Эх орончдын өдөрт” зориулсан үзэсгэлэн 18 ширхэг номоор,
- “Монгол цэргийн өдөр”-т зориулан үзэсгэлэн 20 ширхэг номоор,
- “Олон улсын сансрын нисгэгчдийн өдөр”-т 22 ширхэг номоор,
- “Түүхийн эх сурвалж” сэдэвт байнгын үзэсгэлэн 54 ширхэг номоор,
- “Ногоон хувьсгал” сэдэвчилсэн үзэсгэлэнг 22 ширхэг номоор,
- “Ном солилцоо”-ны 21 ширхэг номоор,
- “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр”-т зориулан 15 ширхэг номоор,
- “Аугаа их эх орны дайны ялалтын ойд”-т зориулан 21 ширхэг номоор,
- “Үндэсний бичиг үсэг-2019” өдөрт зориулан 20 ширхэг номоор,
- “Олон улсын гэр бүлийн өдөр”-т зориулан гэр бүлийн боловсрол сэдвээр 25 ширхэг номоор тус тус үзэсгэлэн гаргалаа.
- Mongolian Library Update-2019 улсын VI дахь удаагийн зөвлөгөөнд “НОМЫН САН СУДЛАЛ” мэдээлэл сэдэвчилсэн үзэсгэлэнг 38 ширхэг номоор,

- Хүүхдийн зохиолч О.Сундуйн номын үзэсгэлэн 12 ширхэг номоор,
- Хүүхдийн хөгжилд туслах танин мэдэхүйн АПП-ууд үзэсгэлэнг 4 ширхэг хэвлэмэл материалаар,
- Ногоон орчин байгаль эх дэлхийгээ хайрлая үзэсгэлэнг 4 ширхэг хэвлэмэл материалаар,
- Цэвэр агаар-Цэнгэг ус 11 ширхэг хэвлэмэл материалаар,
- Элсэлтийн ерөнхий шалгалт 9 ширхэг хэвлэмэл материалаар,
- Зохиолч Д.Жамъяаны 9 ширхэг номоор,
- Халх голын 80 жилийн ойд зориулан “Бид мартахгүй 1939 он” 12 ширхэг номоор
- Үндэсний номын баярт зориулан “Номтой нөхөрлөө” 20 ширхэг номоор
- Барилгачидын баярт зориулан 13 ширхэг номоор,
- Философийн өдрийг тохиолдуулан философийн номын үзэсгэлэнг 46 ширхэг номоор,
- “Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолын өдөрт-6ш ном, 15 ш хэвлэмэл хуудас
- “Цагаан сар, ёс заншил” 3ш ном, 18 ш хэвлэмэл материал
- Д.Сүхбаатарын мэндэлсний 126 жилийн ойд “Д.Сүхбаатарын намтар 17ш ном, 11ш хэвлэмэл хуудас, 12ширхэг зурагт хуудсаар,
- Олон улсын эх хэлний өдөрт 16ширхэг номоор
- Гэгээн хайрын өдөр буюу Валентины өдөрт 9ширхэг ном, 4ширхэг хэвлэмэл хуудас
- А.М.Горькийн мэндэлсний 150 жилийн ойд зориулан “А.М.Горькийн намтар уран бүтээлийн тухай “-15 ш ном, 4ш хэвлэмэл хуудсаар
- Дэлхийн яруу найргийн өдөрт 24ш номоор
- “Марта 8” үзэсгэлэнг 6ш ном, 6ш захидал
- “Иргэний нийгмийн өдөр” үзэсгэлэн 8ш ном
- “Цэргийн баяр”-т зориулж эрчүүд уран зохиол үзэсгэлэнг 10ш ном
- “Дэлхийн усны өдөр”-т зориулж 9ш хэвлэмэл 2ш ном,
- Олон улсын инээдмийн баяр(4-р сарын 1)-ны өдөрт зориулан 30 ш ном, 2ширхэг хэвлэмэл хуудас,
- Дэлхийн эрүүл мэндийн өдөрт зориулан “Монголчуудын эрүүл амьдрах ухаан, Эрүүлжих ухааны талаарх 18 ширхэг номоор сэдэвчилсэн үзэсгэлэн гаргав. Мөн эрүүл мэндэд хэрэгтэй 15 зөвлөмжийг хэвлэмэл материал,
- Мод тарих үндэсний өдөрт зориулан "Мод бол хүчилтөрөгч үйлдвэрлэгч" сэдэвт үзэсгэлэнг 10ш хэвлэмэл материал,
- Номын сангийн уншигч хүүхдүүдийнхээ танин мэдэхүйн мэдлэгийг өргөжүүлэх зорилгын хүрээнд " Хүүхэд бүрийн гарын ном" сэдэвт үзэсгэлэнг лавлагааны 9ш ном,
- Дэлхийн номын өдөрт зориулан "Орос ардын үлгэрүүд" (1960-2004) 20ш ном, "Дэлхийн шилдэг үлгэрүүд" 36ш ном,
- Хүүхдийн зохиолч Ш.Энхбаярын уран бүтээл 27ш ном,
- Үндэсний бичиг үсгийн баяр тохиолдуулан "Эх хэлний тань мэдлэгт", мөн "Монгол бичгийн түүхээс "үзэсгэлэнг 10 ш ном, 10 ш хэвлэмэл хуудас 14 ш бүтээл, уйгаржин Монгол бичгээр 20 ширхэг ном, Монголчуудын бичиг үсгийн түүхийг 10 ширхэг хэвлэмэл хуудас,
- Бага насны уншигчид даа зориулан "Танин мэдэхүй"-н холбогдолтой 25ш ном,
- Аугаа эх орны дайны ялалтын 74 жилийн ойд зориулан 1941-1945 оны дайнд баатарлагаар тулалдаж эх орноо хамгаалж, амь насаа алдсан зөвлөлтийн эх орны баатрууд, алдарт жанжнуудын тухай 16ширхэг ном,
- Дэлхийн Сувилагч нарын өдөрт зориулан 12ш ном,

- “Олон улсын музейн өдөрт зориулан нийслэл Улаанбаатар хотод байдаг Монголын үндэсний музей, Монголын дүрслэх урлагын музей, Чойжин сүм ламын музей, Богд хааны музейн түүхийг товч дурдсан 8 ширхэг хэвлэмэл хуудас,
- ЭЕШ-д бэлтгэгчдэд зориулан 13 ш гарын авлага,
- Уран зохиолын тань мэдлэгт 10 ш ном,
- Дэлхийн тамхигүй өдөрт зориулан тамхины хор уршгийн тухай 10 ш хэвлэмэл материал,
- Хүүхдийн баярт зориулан “Хүүхдийн инээд\_бидний аз жаргал” үзэсгэлэн 9 ш ном,
- Багш нарын баярт зориулан “Багшийн мэргэжил заах арга зүйн” талаарх 13 ширхэг ном,
- “Ухаан далай номоос эхтэй” номын үзэсгэлэнг нийт 11 ш ном, “Ном унших арга, уншлагын соёлын талаар 2 ш хэвлэмэл хуудас,
- “Олон улсын охидын эрхийг хамгаалах өдөрт зориулан 11 ш ном,
- “Мод тарих үндэсний өдөрт зориулан “Тасалгааны ургамал, цэцэг ургуулах, Тасалгаанд тариалах жимсний модны талаарх 9 ш ном,
- “Улаанбаатар хотын түүхэн замналаас” 3 ш ном, 9 ш хэвлэмэл хуудас,
- “Зөв хооллолт эрүүл амьдралын үндэс” 9 ш ном, 6 ш хэвлэмэл хуудас,
- Улаанбаатар хотын түүх, Нийслэлийн өв соёл, хүрээ хийд, УБ хотын хүн амын тухай холбогдох 29 ш ном болон 7 ш материал,
- “Үлгэрийн ертөнцөөр аялцгаая” сэдэвт монгол ардын үлгэрийн 16 ш ном,
- Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 113 жилийн ойд зориулан 14 ш ном, 7 ш бусад материал зэргээр тус тус үзэсгэлэн гаргалаа.



Үзэсгэлэн худалдаа:

- Дэлхийн номын өдөр: Номын худалдаа эрхэлдэг 13, хувь уран бүтээлч 19 оролцогчтой номын хямдралтай, үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Энэхүү



үйл ажиллагаанд 500 гаруй иргэд хамрагдлаа.

- Цагаан сараар ном бэлэглэе. Номын худалдаа эрхэлдэг 15, хувь уран бүтээлч 22 оролцогчтой номын хямдралтай, үзэсгэлэн худалдааг Цагаан сарын баярыг тохиолдуулан зохион байгууллаа. Уг үзэсгэлэн худалдаанд 700 гаруй иргэд хамрагдсан юм.



- Бяцхан хайгуулч номын өдөрлөг

Хүүхдийн баярыг угтан үр хүүхэддээ чихэр биш дуртай номыг нь авч бэлэглэхийг уриалан, зохиолчийн гарын үсэгтэй хямдралтай номын худалдааг зохион байгуулсан.

Тус арга хэмжээ нь 2019.05.31-ний 10:00-18:00 цагийн хооронд "Улаанбаатар хотын номын сан"-гийн гадна талбайд болсон бөгөөд өдөрлөгийн үеэр урлагийн үзүүлбэрүүд, гэр бүлийн хөгжөөнт уралдаан, тэмцээнүүд явагдсан.

Өдөрлөгт хүүхдийн зохиолч Д.Давааням, Н.Мандал, О.Сундуй, Ш.Энхбаяр, Д.Далхжав, З.Ядмаа Э.Амарзаяа, зохиолч Э.Эрдэнэцэцэг нар арга хэмжээнд маань зочноор ирж, "Интерном", "Монсудар", "Азхур", "Мажестик", "Сэлэнгэ пресс", "Мирном", "Book zone kids", "Ganuna publishing", "empathy" зэрэг ном хэвлэлийн салбарын тэргүүлэгчид цугларч, хямдралтай номын худалдаанд оролцсон.

5.2. Цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт. Үүнд:

- Номын санд жилдээ ном бүрдүүлэлтэд 21 сая төгрөг төсөвлөгддөг. Үүнээс 4,5 сая нь хэвлэл захиалгад, үлдсэн нь ном бүрдүүлэлт. Уншигч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээтэй

нормуудыг худалдан авахад 35%-ийг л хангаж байна. Энэ нь номын сангийн нийт зардлын 3 хүрэхгүй хувийн эзэлдэг. Иймд уншигчдын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн номуудаар номын бүрдүүлэлт хийхэд төсөв мөнгөний хувьд хангалтгүй, хүрэлцээ муутай байна.

- Нийслэлийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” А/920 дугаар захирамжаар 80 хүний орон тоотой баталсан. Батлагдсан цалингийн төсвөөр 68 ажилтан ажиллахаар төсөвлөгдсөн байна. Цалингийн төсөв хүрэлцэхгүй ирсний улмаас өвчтэй, чөлөөтэй, хүүхэд асрах чөлөөтэй ажилтны оронд шинээр ажилтан авч ажиллуулахгүй явсаар ирсэн. 2019 оны 02 дугаар сараас эхлэн хүүхэд асрах чөлөөтэй болон өвчтэй, чөлөөтэй байсан ажилтнууд эргэн ажилдаа орох, мөн ажлын зайлшгүй шаардлагаар нэмж шинээр ажилтан авч ажиллуулж байна.

Иймээс номын сангийн цалингийн төсвийг нэмэгдүүлэх

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:  
ЗАХИРАЛ



Д.ИНДРА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН  
АЖИЛТАН

М.ЭНХ-УЯНГА